# ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭД ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ ГЭЛЭГЖАМЦЫН ЭНХТАЙВАНЫ 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| Зорилт 1: Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах | | | | | | | |
| 1. | 1.1.Дэлхийн худалдааны байгууллагын “Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр”-ийн хэрэгжилтийг хангахтай холбоотой Монгол Улсын авсан үүрэг амлалтыг биелүүлэх, Дэлхийн худалдааны байгууллагаас Монгол Улсын Худалдааны бодлогыг хянасан 2023 оны дүгнэлтийн хэрэгжилтийг хангах | Хэрэгжилт, хувиар, гүйцэтгэлээр | 1. Монгол Улсын Худалдааг Хөнгөвчлөх Үндэсний Хороонд Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн хэрэгжилтийг хүргүүлж 2023 онд 85.3 хувьд хүрсэн.<br>2. ГЕГ-ын 2021 онд худалдааг хөнгөвчлөх чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан, 2023 онд хэрэгжилт хангах үүрэг амлалт авсан арга хэмжээний тайлан хүргүүлж хэрэгжилтийг хангаж ажилласан. | 1. Монгол Улсын Худалдааг Хөнгөвчлөх Үндэсний Хороонд Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн 7 дугаар зүйлийн 5 дахь заалт Бүрдүүлэлтийн дараах шалгалтын биелэлтийг хүргүүлсэн байна. Барааны урьдчилсан шийдвэртэй холбоотой биелэлтийг хүргүүлнэ. Нийт хэрэгжилт 94 хувьтай байна.<br>2. Монгол Улсын Худалдааг Хөнгөвчлөх Үндэсний Хороонд | Монгол Улсын ДХБ-ын өмнө Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн хүрээнд авсан үүрэг амлалтын хэрэгжилт:<br>Монгол Улсын ДХБ-ын өмнө Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн хэрэгжилтийг хангахаар 2016 онд авсан 23.5 хувийн үүрэг амлалтыг 87 хувьд хүргэхийн тулд 2017 оноос хойш өнөөдрийг хүртэлх 7 жилийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлын үр дүнг тоймлон харуулбал:<br>• “ДХБ (WTO), ДГБ (WCO), НҮБ-ын ХХБХ (UNCTAD), НҮБ-ын Ази, Номхон далайн бүс нутгийн эдийн засаг, нийгмийн комисс (UNESCAP), Европын эдийн засаг, нийгмийн комисс (UNECE)” болон бусад олон улсын байгууллага, гадаад орны ижил чиг үүргийн байгууллагатай хамтран ажиллаж ойролцоогоор 169 албан бичиг, 2,730 цахим захидал солилцон, 178 гадаад болон дотоод арга хэмжээ (71 уулзалт, 108 ерөнхий болон тусгайлсан чиглэлийн сургалт)-нд цахим болон биет хэлбэрээр чиглэл хариуцсан албан хаагчдыг оролцуулж, худалдааг хөнгөвчлөх чиглэлээр төр хувийн хэвшлийн | 2024.01.01 - 2024.11.30 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн 2 заалт (7.4. Эрсдэлийн удирдлага, 10.3. Олон улсын стандарт ашиглах)-ын биелэлтийг хүргүүлсэн байна. Нийт хэрэгжилт 73 хувьтай (67.4+5.6) байна.<br>3.Монгол Улсын Худалдааны бодлогыг дүгнэсэн 2021 оны тайлангийн хэрэгжилтийг хангасан байна. | чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажилласан.<br>• Худалдааг Хөнгөвчлөх Үндэсний Хорооны 2017-2022 онуудад хийсэн 7 хуралдаанд Гаалийн байгууллага гол үүрэгтэй оролцож, тайлант хугацаа бүрээр тус байгууллагаас хэрэгжүүлсэн тайланг хүргүүлж, хэлэлцээрт тусгасан 36 арга хэмжээ тус бүрээр "хууль эрх зүй, үйл ажиллагаа, мэдээллийн технологи" гэсэн чиглэлээр төрөлжүүлэн, өнөөгийн нөхцөл байдлын болон зөрүүгийн шинжилгээ хийж, үр дүнг 2021, 2022 оны хуралдаанд танилцуулж, зарим "B", "C" ангиллын заалтын хэрэгжилтийг хугаацаанд нь хханган ажилласан үр дүнд хүрсэн.<br>• ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хороонд "C" ангилалд багтсан зарим заалтын хүрээнд техникийн туслалцаа авах хүсэлтийг 2019 онд цахим хэлбэрээр ДХБ-ын "Худалдааг хөнгөвчлөх байгууламж" (https://www.tfafacility.org/tfaf-activity) программын дагуу хүргүүлсэн. Үүнтэй уялдуулан Монгол Улсын Худалдааг хөнгөвчлөх үндэсний хорооноос Нарийн бичгийн даргын газарт Монгол Улсад "*Зүйл 3. Урьдчилсан шийдвэр; Зүйл 7.1 Бичиг баримтын бүрдүүлэлтийг бараа ирэхээс өмнө хийлгэх; Зүйл 8. Хилийн хяналтын байгууллагуудын хамтын ажиллагаа"* заалтад тусгасан арга хэмжээний хүрээнд техникийн туслалцаа авахад зориулж олон улсын эксперт ажиллуулж, хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлсэн.<br>• Үндэсний хороотой хамтран ажиллаж, Монгол Улсын өнөөгийн нөхцөл байдал, хэлэлцээрийн зарчимтай хэрэгжилтийг харьцуулан зөрүүгийн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээний саналыг бэлтгэн, дараах 5 арга хэмжээг хэрэгжүүлэх анхны | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үүрэг амлалтын хугацааг 1-5 жилээр хойшлуулах үндэслэл бүхий хүсэлтийг ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хороонд хүргүүлж, шийдвэрлүүлсэн:<br>- Зүйл 3. Барааны урьдчилсан шийдвэр,<br>- Зүйл 7.5 Бүрдүүлэлтийн дараах шалгалт,<br>- Зүйл 8. Хилийн хамтын ажиллагаа,<br>- Зүйл 10.3 Олон улсын стандарт хэрэглэх,<br>- Зүйл 10.4 Нэг цонхны систем.<br>Дараах зурагт Монгол Улсын ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах үүрэг амлалтын биелэлтийг 2020 оноос 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар үзүүллээ.<br><br><br>Монгол Улсын “A” болон “B” ангиллын хүрээнд авсан үүрэг амлалт 59.6 хувь буюу бүрэн хэрэгжсэн, “C” ангиллын хувьд 2024 оны сүүл болон 2025 онд дараах зүйлийн хэрэгжилтийг хүргүүлж, Монгол Улсын ДХБ-ын өмнө Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн хүрээнд авсан үүрэг амлалт бүрэн биелэх хүлээлттэй байна.<br>- Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн 3 дугаар зүйлийн барааны ангиллын кодыг урьдчилан тодорхойлохтой холбоотой заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ГЕГ-ын даргын 2008 оны 692 дугаар тушаалаар батлагдсан “Барааны ангиллын кодыг | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | урьдчилан тодорхойлох журам"-ыг шинэчлэн боловсруулж, журмын төслийг гаалийн байгууллагын цахим хуудсанд санал авахаар байршуулахаас гадна холбогдох нэгжүүдээс санал авсан. Тушаалын төслийг Мэргэжлийн зөвлөлийн хурлын хэлэлцүүлэн ГЕГ-ын даргын 2022 оны 02-р сарын 09-ний өдрийн А/25 дугаар тушаалаар батлуулж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 5720 дугаарт бүртгүүлэн хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлсэн. Дээрх тушаалыг гаалийн байгууллагын дотоод сүлжээ болон цахим хуудсанд байршуулан гаалийн харилцаанд оролцогчид мэдээлэл авах боломжийг бүрдүүлсэн.<br>- Гаалийн байгууллагын цахим үйлчилгээний системээр барааны ангиллын кодыг урьдчилан тодорхойлуулах хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх програмын шийдлийн талаар "Аствишн" компанийн мэргэжилтэнтэй уулзаж ярилцан, аж ахуйн нэгж, иргэн хүсэлтээ програмаар илгээх, гаалийн байгууллага хүсэлтийг нь хүлээн авах эсвэл татгалзах, нэгжийн дарга хүсэлтийг хуваарилах, хуваарилагдсан ГУБ хүсэлтийг шийдвэрлэх, нэмэлт материал авахаар тайлбар бичиж буцаах, ГУБ-ийн гаргасан урьдчилсан шийдвэрийг нэгжийн дарга хянаж баталгаажуулах үйлдлүүд бүрэн хийгдсэн. Програмыг туршиж үзэн хүсэлт болон шийдвэрийн маягтын дутуу мэдээллийг нэмж оруулах, хуваарилагдсан ГУБ-ийг солих үйлдлийг нэмж хийх зэрэг саналыг 3 удаа өгч сайжруулалтыг хийлгэн бэлэн болгосон. Програмын туршилтыг хийж байна. Хүсэлтийг энэхүү програмаар хүлээн авч шийдвэрлэснээр шийдвэрийн сан бүрдэх юм. | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2. | 1.2.Гадаад орны гаалийн байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд гадаад худалдааны мэдээлэл солилцох үйл ажиллагааг хөгжүүлэх | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 1. БНХАУ-ын 5 боомтын зэрэгцүүлэлтийг хийсэн.<br>2. ОХУ-ын зүгээс биечлэн зэрэгцүүлэлт хийх боломжгүй гэх хариуг ирүүлсэн. | 1.Боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, бараа, тээврийн хэрэгслийг хилээр нэвтрүүлэх цаг хугацаа буурсан байна.<br>2.Хөрш орны гаалийн байгууллагатай хилийн хяналтын үйл ажиллагааг уялдуулах зорилгоор хамтарсан шалгалт хийх, харилцан бичиг баримтыг хүлээн зөвшөөрөх, гадаад худалдааны статистик зэрэгцүүлэлтийн чиглэлээр хамтын ажиллагааг үнэлж, дүгнэн, цаашдын чиглэлийг тодорхойлсон байна.<br>3.БНХАУ-тай 2023 оны гадаад худалдааны статистик зэрэгцүүлэлт хийсэн байна.<br>4.ОХУ-тай 2023 оны гадаад худалдааны статистик | 1. БНХАУ-тай хил залгаа боомтуудаар 2023 оны эхний 11 сард 551658 тээврийн хэрэгслээр экспортын эрдэс бүтээгдэхүүн тээвэрлэж байсан бол 2024 оны эхний 11 сард 646668 тээврийн хэрэгслээр экспортын эрдэс бүтээгдэхүүн тээвэрлэж, тээвэрлэлт 17.2 хувиар нэмэгдсэн.<br>-ОХУ-тай хиллэдэг авто замын боомтоор 2023 оны 11 дүгээр сарын байдлаар суудлын 250783, ачааны 56373 тээврийн хэрэгсэл хилээр нэвтэрсэн бол 2024 оны 11 дүгээр сарын байдлаар суудлын 270438, ачааны 61225 тээврийн хэрэгсэл тус тус хилээр нэвтэрсэн. Үүнээс харахад ОХУ-тай хиллэдэг боомтуудаар нэвтрэх суудлын тээврийн хэрэгслийн тоо 7.8 хувиар, ачааны тээврийн хэрэгслийн тоо 8.6 хувиар нэмэгдсэн.<br>2. Монгол Улс, БНХАУ-ын гаалийн байгууллагын 2023 оны хилийн хамтарсан шалгалтын ажлын хэсгийн 9-р хуралдааны Протоколын Монголын талын хэрэгжилт 94.2, Протоколыг хэрэгжүүлэх 9 арга хэмжээтэй төлөвлөгөөний биелэлт 86.6 хувьтай байна.<br>2.1 Монгол Улс, БНХАУ-ын хилийн гаалийн байгууллагын холбоо баригч дарга нарын 2023 оны хуралдааны Протоколын Монголын талын хэрэгжилт 95, Протоколыг хэрэгжүүлэх 13 арга хэмжээний биелэлт 98.1 хувьтай байна.<br>2.2. Монгол Улсын ХБГ болон ОХУ-ын ХГА-ны Сибирийн гаалийн газар, Алс Дорнодын гаалийн газар хоорондын хилийн холбоо баригч дарга нарын 2023 оны уулзалтын Протоколын Монголын талын хэрэгжилт 95, Протоколыг хэрэгжүүлэх 9 арга хэмжээний биелэлт 98.8 хувьтай байна.<br>2.3. ОХУ-ын ХГА-аас 2024.04.19-ний өдөр ирүүлсэн “Монгол Улсын ГЕГ, ОХУ-ын ХГА хоорондын рентген тоног төхөөрөмж ашиглан мэдээлэл солилцох тухай хэлэлцээр”-ийг | 2024.01.01<br>-<br>2024.11.30 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | зэрэгцүүлэлт хийсэн байна.<br>5.Өмнөх оны зэрэгцүүлэлтийн зөрүүний учир шалтгааныг тогтоож, зөрүүг багасгахтай холбоотой арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. | шинэчлэх төсөлтэй танилцаж, саналаа 2024.06.12-ны өдрийн ГХАХ-аар уламжлуулан ОХУ-ын ХГА-д хүргүүлсэн.<br>2.4. БНХАУ-ын ГЕГ-аас 2024.06.05-ны өдөр имэйлээр ирүүлсэн "Хяналт, шалгалтын үр дүнг харилцан хүлээн зөвшөөрөх" төсөлтэй танилцаж саналаа 2024.06.10-ны өдрийн 231 дугаартай дотоод зурвасаар ГХАХ-аар уламжлуулан БНХАУ-ын ГЕГ-т хүргүүлсэн.<br>3. Хөрш орны гаалийн байгууллагатай хилийн хяналтын үйл ажиллагааг уялдуулах зорилгоор хамтарсан шалгалт, холбоо баригч дарга нарын уулзалтыг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангасан боловч ОХУ-ын ХГА, БНХАУ-ын ГЕГ-аас 2024 оны уулзалтуудыг зохион байгуулаагүй хойшлуулсан. Мөн БНХАУ-ын талаас 2023 оны гадаад худалдааны статистикийн зэрэгцүүлэлтийг хийх боломжгүй гэж ГЕГ-ын ГХАХ-ээр дамжуулан мэдэгдсэн болно.<br>4. МУ-ын гаалийн байгууллагаас БНХАУ болон ОХУ-ын гаалийн байгууллага руу барааны статистик зэрэгцүүлэлтийн мэдээллээ ирүүлэх талаар албан хүсэлт тавьсны үндсэн дээр ОХУ-аас 2023 оны статистик мэдээллийг ирүүлсэн. Монгол улс, ОХУ хооронд 2023 онд хийсэн гадаад худалдааны барааг БТКУС-ийн орон тус бүрээр зөрүүг гаргах, их зөрүүтэй барааг тогтоох, зөрүүг нарийвчлан шалгах, учир шалтгааныг тогтоох зэрэгцүүлэлтийн ажлыг 2024 оны 9 дүгээр сарын 10-аас хийж ОХУ-ын Холбооны гаалийн албанд хүргүүлэх ажлыг зохион байгуулсан.<br>Монгол улс, ОХУ-ын хооронд 2023 онд хийсэн гадаад худалдааны статистикийн зэрэгцүүлэлт хийх экспертүүдийн 4 дүгээр уулзалт 2024.10.03-аас 2024.10.04-ний өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан бөгөөд 2 талын санал солилцсон экспортын 10, импортын 12 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | барааны зэрэгцүүлэлтийг хийж, зөрүү үүссэн шалтгааныг нарийвчлан тогтоосон. Зэрэгцүүлэлтийн уулзалтыг протокол үйлдэн баталгаажуулан ГХАХ-т хадгалуулсан. Монгол улс, ОХУ хооронд хийсэн гадаад худалдааны 2023 оны статистикийн зэрэгцүүлэлт хийсэн тайланг ГЕГ-ын Мэргэжлийн зөвлөлийн хуралд танилцуулан, хэлэлцүүлэхээр бэлэн болгож 26 хуудас материалыг ЗУГ-т хүргүүлэх ажлыг зохион байгуулан ажилласан.<br>5. Монгол улс, БНХАУ-ын ӨМӨЗО-той хиллэдэг 5 боомтын 2022 оны статистикийн мэдээллийн зэрэгцүүлэлтийг 2023 оны 12 дугаар сард хийсэн бөгөөд ГЕГ-ын МЗХ-аар 2024.06.14-ний өдөр оруулсан баталгаажуулан хурлаас гарсан шийдвэрийн дагуу цаашид авах арга хэмжээний талаар ЗББНДБ болон харьяа гаалийн газар хороодод зөвлөмж, чиглэлийг хүргүүлсэн.<br>**Статистик эрэгцүүлэлтийн ажлын үр дүнд:**<br>- Нүүрсний экспортын зөрүү үүсэх шалтгаан нь хүлээн авагч улсыг гаалийн мэдүүлэгт буруу бичиж байсныг тогтоосон бөгөөд алдааг залруулах ажлын хэсгийг ГЕГ-ын даргын тушаалаар байгуулан Гашуунсухайт, Шивээхүрэн дэх гаалийн газруудад нүүрсний экспортын бүрүүлэлт хийгдсэн 2022, 2023 оны гаалийн мэдүүлгүүдийг засварласан. Мөн цаашид нүүрсний экспортын гаалийн мэдүүлгийг нөхөн бичихдээ хүлээн авагч улсыг зөвхөн "БНХАУ" байх талаар албан тоотоор чиглэл өгч ажилласаны үндсэн дээр 2024 онд энэ төрлийн алдаа гараагүй байна.<br>- Ханги ГГ-т өгсөн чиглэлийн дагуу тус гаалийн газар арга хэмжээ авч цахилгаан эрчим хүчний гаалийн бүрдүүлэлтийг 2024 оны 8 сараас эхлэн мэдүүлж эхэлсэн ба төсөвт 52.2 сая төгрөгийн татварыг оруулсан байна. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3. | 1.3.Гаалийн хяналтад эрсдэл тооцох системийг боловсронгуй болгох | Гаалийн хяналтад эрсдэл тооцох системийг боловсронгуй болгох ажлын хэрэгжилт, гүйцэтгэлээр, хувиар | 1-2.Гаалийн байгууллага эрсдэлийн дүн шинжилгээ хийж, хууль сахилтын түвшингээр үнэлж, 593 эрсдэлийн шалгуур үзүүлэлтийг боловсруулж, батлуулж, программд оруулсан. Нийт 1416 эрсдэлийн шалгуурын үр дүнд тухайн шалгуурт баригдсан гаалийн бүрдүүлэлтийн бараанд хийх шалгалтаас чөлөөлөгдөх хувь хэмжээ экспортын гаалийн бүрдүүлэлтийн хувьд 22.7 хувиар, импортын гаалийн бүрдүүлэлтийн хувьд 9 хувиар нийт гаалийн бүрдүүлэлтэд бараанд хийх шалгалтаас чөлөөлсөн хувь хэмжээ 15.45%-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна.<br>3.Гадаад худалдаа эрхлэгчийн хууль сахилтын түвшинг | 1.Бичиг баримтын болон бараанд хийх шалгалтаас чөлөөлөх хувь хэмжээг 30 хувиар нэмэгдүүлнэ.<br>2.Худалдааг хөнгөвчлөх чиглэлээр эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийг 65 хувьд хүргэнэ.<br>3.Аж ахуйн нэгж өөрийн хууль сахилтыг өөрөө үнэлдэг, гаалийн байгууллагатай хууль сахилтыг дэмжих чиглэлээр хамтран ажиллах боломжийг бүрдүүлсэн байна.<br>4.Төмөр зам болон авто замын тээврээр зорчих зорчигчийн мэдээллийг ашиглан эрсдэл тооцох боломжийг бүрдүүлэхийн тулд "Эрсдэлтэй зорчигчийг онилох систем"-ийн хөгжүүлэлтийг хийсэн байна. | 1. Бичиг баримтын болон бараанд хийх шалгалтаас нийт мэдүүлгийн 63.1%-ийг чөлөөлсөн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 3.5%-иар өссөн. Мөн эрсдэлийн мэдээллийн санд шалгуур оруулж, баяжилт хийсэн байдал нь өнгөрсөн оны мөн үеэс 5 шалгуураар өссөн үр дүнтэй байна.<br>2. Системийн хэмжээнд ЭУ-д суурилсан ГХ-ын үр нөлөөг дээшлүүлэх, эрсдэлт орчныг тодорхойлох, судалгаанд суурилсан шийдвэр гаргах, гаалийн байгууллагын гүйцэтгэлийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор макро түвшний 7, микро түвшний 19 судалгааг хийж гүйцэтгэсэн.<br>3. ЭУ-ын программын мэдээллийн санд 9 профайл, 95 хяналтын хуудсаар 483 шалгуур үзүүлэлтийг боловсруулж, оруулан ЭУ-д суурилсан ГХ-ыг хэрэгжүүлж ажилласан. Япон Улсаас БТКУС-ийн 8703 зүйлийн түвшинд суудлын машин импортлох иргэдийн судалгааны үр дүнд эрсдэлийн ШҮ боловсруулж, ЭУ-ын программд оруулж, ГБ-д зарцуулах цаг хугацааг бууруулсан.<br>4. ЭУ-д суурилсан ГХ-ын үр дүнг үндэслэн БДШ-д хамруулахаар "Эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн хүсэлт", "Шалгалтын үр дүнгийн санал", Зөрчилд холбогдсон байдал", "Эрсдэлийн дүн шинжилгээний үр дүн"-ийн хүрээнд 302 ААН-ийн жагсаалтыг гаргах ажлыг зохион байгуулсан. Түүнчлэн Улсын төсвийн орлогоос зайлсхийх эрсдэлт орчныг тодорхойлох, түүнийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр ЗҮГГ-т ААН, иргэдийн гаалийн бүрдүүлэлтийг итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан хийж буй байдалд дүн шинжилгээг хийж, 259 ААН-ийн жагсаалтыг БДШГ-т хүргүүлсэн. Үүнээс 20 ААН-д 2024.06.20 байдлаар БДШ хийх удирдамж батлагдаж, шалгалт орсон. 12ААН бүрэн дуусч 9-д зөрчил илэрсэн. | 2024.01.01<br>-<br>2024.11.30 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тодорхойлох загварыг боловсруулж, Гаалийн хяналтад эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журмын төсөлд оруулсан.<br>4.Зорчигчийн мэдээллийг урьдчилан авч эрсдэл тооцож ажиллаж байна. Эрсдэлийн мэдээллийн санд 2023.11.30-аар 247 эрсдэлтэй зорчигч, 2022 онд 218 эрсдэлтэй зорчигч тус тус бүртгэгдсэн. Бүртгэсэн эрсдэлтэй зорчигчийн тоо нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11.7 хувиар өссөн. Эрсдэлийн мэдээллийн санд гаалийн байгууллага эрсдэл тооцсоны үр дүнгээр 78.9%, бусад байгууллагын 21.1%-ийн мэдээллийн эх сурвалжид | | Зорчигчийн бэлэн мөнгө мэдүүлсэн байдалд дүн шинжилгээ хийхэд 17 валютаар мэдүүлсэн байна. Үүнээс хамгийн их буюу 86.7% рубль (255.43 сая), 5.9% ам. доллар (13.4 сая), 2.9% юань (14.6 сая), үлдсэн 4.5% бусад 14 улсын валют эзэлжээ. Үүнийг 2023 онтой харьцуулахад 14 улсын валютаар мэдүүлснээс 84.2% рубль (508.2 сая), 8.9% ам.доллар (6.9 сая), 2.8% юань, үлдсэн 4.1% бусад 11 улсын валют эзэлжээ.<br>Зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлийг гаалийн хилээр нэвтрүүлэх журмын дагуу Маягт1; 2-ыг авч үзэхэд Маягт1-ын 4,642 бүрдүүлэлт хийсийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2.54 дахин өссөн. Маягт2-аар 10,613 бүрдүүлэлт хийснийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2.65 дахин өссөн байна. Стратегийн түвшний өндөр эрсдэл бүхий эк, им-ын бүрд-тэй холбоотой шалгуур үзүүлэлтийг тухай бүр боловсруулан, баяжилт, анхааруулгын хамт ор-ж, эрсдэлийг бууруулсан. ГХ-ны бараа эргэлт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 14%-аар, төсвийн орлого 27%-аар өсөхөд нөлөөлсөн. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | үндэслэн бүртгэсэн байна. Одоогоор төмөр зам болон авто замын тээврээр зорчих зорчигчийн мэдээлэлд эрсдэл тооцох боломж бүрдээгүй байна. | | | | |
| 4. | 1.4.Гаалийн бүрдүүлэлтийн цаг хугацааны судалгаа хийх арга зүйг боловсронгуй болгон, бүрдүүлэлтийн цаг хугацааг бууруулах үйл ажиллагааг зохион байгуулах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр Гаалийн хяналт, бүрдүүлэлтэд зарцуулах хугацаа, хувиар, Төлөвлөгөөний хэрэгжилт, хувиар | 1.2019 оны Гаалийн бүрдүүлэлтийн цаг хугацааны судалгааны дүн шинжилгээнд үндэслэн боловсруулсан бүрдүүлэлтийн цаг хугацааг бууруулах төлөвлөгөөний биелэлт 98 хувьтай байна. "Гаалийн бүрдүүлэлтийн цаг хугацааны судалгаа"-г 2023 онд хийсэн.<br>2.2019 онд хийгдсэн "Гаалийн бүрдүүлэлтийн цаг хугацааг бууруулах судалгаа"-ны дүнтэй 2023 онд хийсэн судалгааг харьцуулж байна. | 1.Гаалийн бүрдүүлэлтийн цаг хугацааны судалгааг хийж дуусгасан, тайлан гарсан байна.<br><br>2.2019 онтой харьцуулахад бүрдүүлэлтэд зарцуулах хугацаа 5 хувиар буурсан байна. | "Бүрдүүлэлтийн цаг хугацаа"-ны судалгаа (Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр Зүйл 7.6) хийсэн:<br>ГЕГ-аас 2010, 2012, 2014, 2017, 2019 онд ДГБ-ын Бүрдүүлэлтийн цаг хугацааны судалгааны дагуу бараа олгох дундаж хугацааны судалгаа хийгдсэн. Бүрдүүлэлтийн цаг хугацааны 2023 оны судалгааг хийхдээ 2023 оны 11 дүгээр сарын 06-14-ний өдрүүдэд хийгдсэн бүрдүүлэлтийн мэдээллийг 2022 он, 2019 оны мөн үетэй харьцуулж шинжилгээ хийсэн. Өмнө хийсэн судалгаатай харьцуулахад судалгаанд хамрагдсан хугацаанд эзэнд нь олгосон бүх бүрдүүлэлтийг анх мэдүүлсэн үеэс нь эхлэн тооцоолсноор онцлог юм. Судалгааны үр дүн:<br>- Судалгаанд 2023 онд 7,572 мэдүүлэг хамрагдсаныг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 567 мэдүүлгээр илүү буюу 7 хувиар өссөн байна. Судалгаанд ажиглагдсан утгын тоо 2022, 2023 онд ойролцоо тул судалгааны үр дүн ижил гарах боломжтой. Сонгон авсан хугацааны 2023 оны бүрдүүлэлтэд 251.58 мянган цаг зарцуулсныг 2022 онтой харьцуулахад 1 хувиар буурсан байна.<br>- ГЕГ-ын 2019 оны Бүрдүүлэлтийн цаг хугацааны судалгаатай 2023 оны судалгааг сонгон авсан гаалийн газар, хороодоор харьцуулахад "Тээвэрлэлт, Татвар төлөх хугацаа, Хорио цээрийн шалгалт, Гаалийн | 2024.01.01<br>-<br>2024.11.30 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | лабораторийн шинжилгээ" зэрэг үйл ажиллагаа бүрдүүлэлтийн цаг хугацааг нэмэгдүүлэхэд хамгийн их нөлөө үзүүлжээ.<br>- Бүрдүүлэлтийн цаг хугацааны 2023 оны судалгааг 2019 оны судалгаатай харьцуулахад зөрүүтэй байгаа нь өгөгдөл/мэдээлэл цуглуулсан, боловсруулсан аргачлалын хувьд ялгаатай байгаатай холбоотой. Үүнтэй уялдуулан хоёр судалгааны ижил болон ялгаатай талыг харьцуулан харуулсан.<br>- Шинжилгээг дундаж утгын хүрээнд авч гүйцэтгэхэд 2023 онд 1,993.5 минут зарцуулсныг 2022 оны мөн үетэй харьцуулахад 8 хувиар буурсан. Тус бууралтад нөлөөлсөн гол үе шат нь бичиг баримтын шалгалт 64 хувиар буурсантай холбоотой.<br>- Голч утга (медиан)-аар авч үзэхэд 2023 онд 267.5 минут байгаа нь 2022 оны мөн үетэй харьцуулахад 25 хувиар өссөн бөгөөд үүнд хорио цээрийн шалгалтад 2023 онд зарцуулсан дундаж болох 841 минут/14 цагийг 2022 оны мөн үетэй харьцуулахад 136 минут/16 хувиар өссөн нь нөлөөлжээ.<br>- Шинжилгээний үр дүнд "Хорио цээрийн шалгалт болон ГУАБ зөвшөөрөх" үе шат нь дундаж хугацаанаас хэт хазайлттай гарсан. Энэ нь тухайн үе шатанд тооцоолол хийхэд хүндрэл учруулах эрсдэлийг бий болгожээ. Бусад үе шатын хувьд 40-124 минут/0.7-2.06 цагаар буурсан байна.<br>- Бүрдүүлэлтийн үе шат бүрээс онцгой ахиц дэвшил бичиг баримтын шалгалтад зарцуулсан дундаж хугацааг 2022 оны мөн үетэй харьцуулахад 124 минут буюу 2.77 дахин буурсан нь бичиг баримтын шалгалтыг нэг цэгт төвлөрүүлэн цахим хэлбэрээр хийх болсонтой холбоотой юм. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5. | 1.5.Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн хөтөлбөрийг олон улсын стандартын дагуу бүрэн хэрэгжүүлэх, хөтөлбөрийн хүрээнд байгуулсан "Харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр"-ийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх | Хэрэгжилт, гүйцэтгэлээр, Туршилт хийсэн болон шалгаруулсан аж ахуйн нэгжийн тоогоор | 1.ОХУ-тай гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийг харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр байгуулах арга хэмжээний суурь тавигдсан.<br>2. ГЕГ-ын даргын 2021 оны А/118 тушаалаар батлагдсан "Худалдааг хөнгөвчлөх, аюулгүй байдлын стандартыг хангасан аж ахуйн нэгжид гаалийн итгэмжлэл олгох журам"-ын дагуу "ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР" төрийн өмчийн үйлдвэрийн газарт үйл ажиллагаанд 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдөр "Гаалийн итгэмжлэл" олгосон. | 1.Гаалийн итгэмжлэлийг гадаад худалдаанд оролцогчдын бусад төрлөөр олгох ажлыг зохион байгуулсан байна. "Харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр" байгуулах орны тоог 1-2-оор нэмэгдүүлэх саналыг хүргэж, бэлтгэл ажлыг хангасан байна.<br>2.Итгэмжлэгдсэн 1-2 аж ахуйн нэгжийг шалгаруулсан байна. | 1. Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн хөтөлбөрийн хүрээнд үзүүлэх хөнгөлөлтийг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх зорилгоор "Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн программ"-ыг боловсруулан, нэвтрүүлсэн. Үүнд:<br>- Гаалийн цахим үйлчилгээний системд "Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж хөтөлбөр" (AEO)-т хамрагдах хүсэлт гаргах программ;<br>- Гаалийн үйлчилгээний хүсэлтийн бүртгэл, хяналтын программ.<br>- CAIS эрсдэлийн удирдлагын программд гадаад худалдааг хөнгөвчлөх чиглэлээр "Зөвшөөрөгдсөн", "Үл хамаарах" эрсдэлийн шалгуурыг баяжуулсан. 2024 оны байдлаар худалдааг хөнгөвчлөх чиглэлээр 527 эрсдэлийн шалгуур ажиллаж байна. "Эрсдэлийн мессеж сан"-г ашиглалтад оруулсан. ГИААН-ийн программ хангамжид хөгжүүлэлт хийсэн. Тус программ нь Гадаад худалдааг хөнгөвчлөх, аж ахуйн нэгжийн хууль сахилтыг тодорхойлоход чухал үүрэгтэй юм.<br>БНХАУ болон БНСУ-тай байгуулсан "Харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр"-ийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангасан. "Харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр" байгуулах орны тоог нэмэгдүүлэх талаар судалгаа хийж, ОХУ-ын гаалийн байгууллага, Европын холбооны Монгол Улсын худалдааг хөгжүүлэх төсөл хэрэгжүүлэгч баг, Их түмэн санаачилга зэрэг байгууллагудтай хамтран ажиласны үр дүнд Харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээрийн хүрээг нэмэгдүүлэх боломж бүрдсэн)<br>2. Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийг шалгаруулсан. Үүнд:<br>- Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын хүсэлтийг судалж, гаалийн итгэмжлэл олгох шалгуурыг үнэлж баталгаажуулсан. Мэргэжлийн зөвлөлийн хуралдааны 2023 оны 11 дүгээр сарын 23-ны | 2024.01.01<br>-<br>2024.11.30 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | өдрийн хуралдааны 08/01 дүгээр шийдвэрээр тус ТӨҮГ-ын экспортын үйл ажиллагаанд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг дуусталх хугацаанд нэг жилийн хугацаагаар гаалийн итгэмжлэл олгохоор шийдвэрлэсэн.<br>МЗХ-ны шийдвэрийн дагуу ГЕГ-ын даргын 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/640 дүгээр тушаал Гаалийн итгэмжлэл олгож, тус ТӨҮГ-т ГИААН-ийн гэрчилгээ гардуулсан.<br>- .“Говь” ХК, “АПУ” ХК, “Ханбогд Кашимер” ХХК-д Гаалийн итгэмжлэл олгох шалгуурыг үнэлэх, баталгаажуулах ажлыг удирдамжийн дагуу зохион байгуулсан. Баталгаажуулалтын үр дүнд 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны 09/02 дугаар шийдвэрээр тус аж ахуйн нэгжүүдийн экспорт, импортын үйл ажиллагаанд 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн гурван жилийн хугацаагаар гаалийн итгэмжлэл олгохоор шийдвэрлэсэн. МЗХ-ны шийдвэрийн дагуу ГЕГ-ын даргын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/661, А/662, А/663 дугаар тушаалаар Гаалийн итгэмжлэл олгосон. | | |
| 6. | 1.6.Гадаад худалдааны үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомж, дүрэм, журам, түүнийг зохицуулсан үйл ажиллагаа, гадаад худалдааны статистик мэдээллийг монгол, англи хэл дээр түгээх, гадаад худалдааны нэгдсэн портал бий болгох, хэрэглэгчдэд холбогдох мэдээллийг түргэн шуурхай, энгийн байдлаар хүргэх | Цахим хуудсаар лавлах цэгээр түгээсэн мэдээллийн тоо, Цахим хуудасны хандалтын тоо, Лавлах цэгээр үйлчлүүлсэн | 1.Гаалийн болон бусад хууль тогтоомжийн мэдээллийг тухай бүр цахим хуудсаар дамжуулан түгээсэн.<br>2."E-Mongolia" системд "Гаалийн мэдүүлгээр бүрдүүлэлт хийсэн лавлагаа /иргэн/"-г 2022 оны 11 дүгээр сард 6808 байсан | 1.Гаалийн болон бусад хууль тогтоомжийн мэдээллийг тухай бүр түгээсэн байна.<br>2.Гадаад худалдааны статистик мэдээллийг хүлээн авсан хэрэглэгч /хандалт/, цахим лавлагаа авсан хэрэглэгчийн тоо өмнөх оны мөн | 1. Гаалийн цахим үйлчилгээний систем https://gaali.mn/ -ээс “Барааны экспорт, импортын статистикийн мэдээлэл”-ийг 2023 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар 481 аж ахуй нэгж, иргэн авсан хандалт хийсэн бол 2024 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар 1867 аж ахуй нэгж, иргэн авсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1386 хэрэглэгчээр буюу 4 дахин өссөн үзүүлэлттэй байна.<br>2. Гаалийн цахим үйлчилгээний систем https://gaali.mn/-ээс “Гаалийн мэдүүлгээр бүрдүүлэлт хийсэн барааны лавлагаа” авахаар 2023 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар 19934 аж ахуй нэгж, иргэн хандсан бол 2024 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар | 2024.01.01<br>-<br>2024.11.30 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэрэглэгчийн тоо, хувиар, Хэрэгжилт, гүйцэтгэлээр, | бол 2023 оны 11 сарын байдлаар 19705 болсон байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 189 хувиар өссөн үзүүлэлт гарсан.<br>3.Гадаад худалдааны статистикийн ухаалаг хайлтын программын судалгааг хийж, программ хангамжийг боловсруулж, туршин бүрэн ашиглалтад оруулсан.<br>4.Гадаад худалдааны нэгдсэн порталд оруулах үйл ажиллагаа жигдрэн, хэрэглэгчид монгол, англи хэл дээр мэдээлэл хүлээн авах боломжтой болсон.<br>5.Гаалийн баталгаат бүсэд үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, түр агуулах ажиллуулах зөвшөөрөл, | үеэс 5 хувиар өссөн байна.<br>3.Хэрэглэгчдийн мэдээлэл авах хүсэлтийг цахимаар авдаг, хүргүүлдэг болсон байна.<br>4.Гадаад худалдааны порталд "Автомат хариулагч"-аар мэдээлэл өгөх боломжийг бүрдүүлсэн байна.<br>5.Гаалийн байгууллагаас олгож буй Гаалийн түр агуулах ажиллуулах зөвшөөрөл, ТИР горимоор тээвэрлэлт гүйцэтгэх зөвшөөрөл олгох, Оюуны өмчийн эрхэд хамаарах барааг гаалийн бүртгэлд бүртгэх, Экспортлогч, импортлогч аж ахуйн нэгжид гаалийн итгэмжлэл олгох зөвшөөрлийг цахим хэлбэрт бүрэн шилжүүлснээр аж ахуйн нэгжээс гаалийн | 39754 аж ахуй нэгж, иргэн авсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 99%-аар өссөн үзүүлэлттэй байна.<br>3. Гаалийн байгууллагаас СМТТ УТҮГ-тай хамтран Гаалийн тухай хууль тогтоомжийн дагуу ГЕГ-аас олгож байгаа 6 төрлийн тусгай, 1 төрлийн энгийн зөвшөөрөл болон гаалийн хяналтын бүс тогтоолгох, тээвэрлэгч байгууллагад олгодог гаалийн итгэмжлэл шинээр авах болон сунгуулах хүсэлтийг 2022 оны 12 дугаар сараас эхлэн цахимаар хүлээн авч шийдвэрлэж байна. Тусгай зөвшөөрлийн license.mn-ээр 2024.01.02-ны өдрөөс 2024.12.15-ны өдрийн хооронд шинээр ирүүлсэн 121, хугацаа сунгуулах 67 буюу нийт 188 хүсэлтийг хүлээн авч, 139 хүсэлтийг шийдвэрлүүлэн, 49 хүсэлтийг хянаж, баталгаажуулсан.<br>4. Тусгай зөвшөөрлийн license.mn-ээр дээр дурдсан хүсэлтийг цахимаар хүлээн авч хянаж, шийдвэрлэснээр аж ахуйн нэгжүүд цаг хугацаа, орон зайнаас хамаарахгүйгээр хүсэлтээ тусгай зөвшөөрлийн цахим системийг ашиглан илгээх мөн хүсэлтийг нь гаалийн байгууллагын албан хаагч нар хүлээн аваад хянаж, шийдвэрлэх буй бүх үйл явцыг цахимаар харах боломжтой болсон.<br>5. Гаалийн байгууллагын автоматжуулсан CAIS системд ТИР-ын гаалийн урьдчилсан цахим мэдүүлгийн систем (TIR-EPD)-ийг холбох туршилтыг хийж, 2024.11.24-ний өдөр амжилттай нэвтрүүлсэн.<br>Оюуны өмчийн эрхэд хамаарах барааны хяналтыг сайжруулах зорилгоор дээрх барааг бүртгүүлэх хүсэлтийг 2024.10.15-ны өдрөөс gaali.mn-ээр хүлээж аваад sims-т бүртгэдэг болгосон. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | гаалийн хяналтын бүс тогтоолгох, тээвэрлэгч байгууллагад олгодог итгэмжлэл авах ААН-ийн хүсэлтийг тусгай зөвшөөрлийн цахим систем license.mn- ээр хүлээн авч шийдвэрлэж байна. ОУАТХ-ны программ хангамжийн багтай 2023.12.04-ний өдөр цахимаар холбогдож, хоёр талын хугацаа нь дууссан эрх /certificate/-ийг 2023 оны 12 дугаар сард багтаан нээж, мэдээлэл солилцож эхлэхээр тохирсон. | байгууллагад гаргасан хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх, олгох явцыг ил тодорхой болгож, хяналтыг сайжруулна. 6.Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах стандартыг боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна. | | | |
| 7. | 1.7.Гадаад худалдааны цахим нэг цонхны системийг бий болгох | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - ЭЗХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны А/184 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт албан хаагч нар ажиллаж байна. Хилийн үйлчилгээг | “Цахим нэг цонхны систем”-тэй гаалийн байгууллагын үйл ажиллагааг холбох туршилтын ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангасан байна. | ЭЗХЯ-ны ТНБД-ын 2023.08.10-ны өдрийн А/138 дугаартай тушаалаар байгуулагдсан Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 178 дугаар тогтоолын 1 дэх хэсэгт заасан Гадаад худалдааны цахим нэг цонх” мэдээллийн системийг бий болгох, гадаад худалдаатай холбоотой төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх үйл ажиллагааг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан эхлүүлэх чиг үүрэг | 2024.01.01 - 2024.11.30 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | сайжруулах бүс нутгийн төслийн нэгжээс "Цахим нэг цонхны систем"-ийг бий болгоход удирдаж явах болон цаашид дараа авч явах агентлагийг сонгох ажил хүлээгдэж байгаа. Цахим нэг цонх бий болоогүй байна.. | | бүхий ажлын хэсэгт гаалийн байгууллагын төлөөлөл ажиллаж байна.<br>"Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл"-ийг хэрэгжүүлэгч байгууллага өөрчлөгдсөнтэй холбоотойгоор ажлын хэсгийн төлөвлөгөөнд тусгасан хугацааг шинэчилж, үйл ажиллагаа нь зохион байгуулагдана. "Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл"-ийн нэгжээс "Гадаад худалдааны цахим нэг цонх" мэдээллийн системд оролцогч 19 байгууллагын 40 албан хаагчийг хамарсан уулзалт 2024.03.21, 2024.03.25, 2024.06.20-ны өдөр зохион байгуулагдаж, гаалийн байгууллагаас холбогдох мэдээллүүдийг хүргүүлэн ажилласан.<br>ГЕГ-ын 2023.06.02-ны өдөр баталсан төлөвлөгөөний хүрээнд 2024 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан 14 арга хэмжээний биелэлтийг нэгж тус бүрээс гаргууоах ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийг ЭЗХЯ-д хүргүүлсэн.<br>."Гадаад худалдааны цахим нэг цонх" мэдээллийн системийг бий болгох, гадаад худалдаатай холбоотой төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх үйл ажиллагааг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан эхлүүлэх арга хэмжээг ЦХХХЯ-тай хамтран хэрэгжүүлэхийг Монгол Улсын Шадар сайд бөгөөд ЭЗХЯ-ны сайд, Хөрөнгө оруулалт, худалдааны газар, ГЕГ-т даалгасаны дагуу дээрх тогтоолын 1.1, 1.4, 3.1-р заалтын биелэлтийг сар бүр тогтмол гаргах ажлыг хэрэгжүүлж, хэрэгжилтийг СЯ-нд хүргүүлэх ажлыг зохион байгуулсан. | | |
| 8. | 2.2.Дэлхийн худалдааны байгууллагын "Гаалийн үнэлгээний хэлэлцээр" болон гаалийн үнэлгээтэй холбоотой хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, гаалийн | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 1.ГЕГ-ын даргын 2012 оны А/30 дугаар тушаалаар батлагдсан "Импортын барааны гаалийн | 1.Эрсдэл тооцох системд үндэслэн гаалийн үнийн хяналтыг оновчтой зохион байгуулах, гаалийн үнийн | 1. Гаалийн үнийн судалгаа болон холбогдох гомдол мэдээллийн дагуу БДШГ-т нийт 27 аж ахуйн нэгжийг шалгуулах саналыг 3 удаа дотоод зурвасаар хүргүүлсэн. 2023 оны 11 сард БДШ оруулах санал өгсөн 3 аж ахуйн нэгжид шалгалт оруулсны 1 аж ахуйн нэгжид | 2024.01.01<br>-<br>2024.11.30 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үнийн хяналтыг оновчтой зохион байгуулах | | үнийг шалгах, гаалийн үнийг тодорхойлох заавар"-ын төслийг боловсруулсан болович бичиг баримтын бүрдүүлэлтийг нэг цэгт төвлөрүүлэн хийдэг болсонтой холбоотойгоор төслийг шинэчлэх шаардлага гарсан.<br>2.Харьяа гаалийн 18 газар, хороодын бичиг баримтын бүрдүүлэлтийг нэг цэгт төвлөрүүлэн хийдэг болсон. | хяналтын тогтолцоонд шинэ хандлага төлөвшүүлсэн байна.<br>2."Гаалийн үнийн хяналтыг цахимжуулах боломжийг судалж эхэлсэн байна. | шалгалтаар зөрчил илрээгүй, 2 аж ахуйн нэгжид 92.4 сая төгрөгийн нөхөн татвар болон торгууль ногдуулсан байна.<br>- Хил орчмын үнийн судалгааны үнээр нийт 110,035 барааны гаалийн үнийг тодорхойлсон бөгөөд нэмж төлүүлсэн татварын зөрүү 21.8 тэрбум төгрөг байна.<br><br>2. ГЕГ-ын даргын тушаалаар батлагдсан үнийн судалгааны ажлын хэсэг 2024.05.12-17-ны өдрүүдэд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Бугат, Эрээн хотуудын барааны зах зээлийн үнийн судалгааг хийх ажлыг зохион байгуулсан. Үнийн судалгаа хийсэний үр дүнд: БНХАУ-ын төмрийн үнийн мэдээллийг цахим хуудаснаас шалгах боломжийг судлан, хандах эрхийн төлбөрийн саналыг авч, санхүүгийн асуудлыг СХОГ-т шийдвэрлүүлсэн. БНХАУ-ын Бээжин хотын Lange Cloud Business Technology Co.,Ltd компанийн төмрийн нээлттэй биржийн цахим хуудас www.lgmi.com-т хандах 1 жилийн албан ёсны эрхийг авч, үнийн хяналтын зорилгоор ашиглах боломжийг бүрдүүлсэн. Тус цахим хуудаснаас төмрийн өдөр бүрийн үнийн мэдээллийг хотуудаар болон 6 сараар харах, мөн тээврийн зардлыг харах боломжтой юм. Цаашид цахим хуудасны хандах эрхийн санхүүгийн асуудлыг жил бүрийн гаалийн байгууллагын төсөвт оруулан батлуулах ажлыг хэвшүүлснээр гаалийн үнэлгээний гомдлын ихэнх хувийг эзэлдэг төмрийн өдөр тутмын үнийн мэдээллийг харах боломжтой болж, үнийн хяналт сайжирна.<br>- Бугатын төмрийн үйлдвэр болон "Norinco group"-ийн хүнд машин механизмын үйлдвэр, Beiben Truck-ийн борлуулалтын үнийн мэдээллийг авч, цаашид үнийн хяналтын зорилгоор тухай бүр үнийн мэдээлэл авахаар холбоо барих боломжийг бүрдүүлсэн. | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - БНХАУ-д үйлдвэрлэгдсэн суудлын автомашины арлын дугаараар хайлт хийхэд техникийн үзүүлэлт болон үнийн мэдээлэл гардаг цахим хуудасны хаягийг авч, хяналтын зорилгоор ашиглах боломжтой болсон.<br>- Япон улсад экспортын гаалийн бүрдүүлэлт хийгдсэн хуучин автомашины марк, арлын дугаар болон гаалийн үнийн мэдээллийг цахимаар ирүүлэх боломжтой эсэх, мөн биржээр арилжаалагдаж байгаа автомашины үнэ болон холбогдох мэдээллийг хэрхэн авах талаар зөвлөгөө авах хүсэлтийг ГХАХ-ээр дамжуулан Японы гаалийн байгууллагад цахимаар хүргүүлсэн. Японы гаалийн байгууллагаас цахимаар хариу ирүүлэхдээ гаалийн үнийн мэдээллийг ирүүлэх боломжгүй талаар дурдаж, статистик мэдээллийн вэбсайтын хаягыг ирүүлсэн.<br>- Япон улсад дуудлага худалдаагаар арилжаалсан хуучин тээврийн хэрэгслийн мэдээллийг харах боломжтой цахим хуудасны талаар судалсны үндсэн дээр ОХУ-ын aleado.ru цахим хаягийн Монгол дахь төлөөлөгчид 2024.11.06-нд албан бичгээр хандсаны дагуу Алеадо ХХК-ийн гүйцэтгэх захирал И.В.Бороков нь албан бичгээр хариу мэдээлэл ирүүлсэн. Тус компанийн төлөөлөгчтэй 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр Гаалийн ерөнхий газарт уулзалтыг зохион байгуулсан.Уулзалтаар тухайн сайтын талаар тодорхой мэдээлэл авсан бөгөөд бусад орнуудтай хэрхэн хамтарч ажилладаг талаар болон сайтын эрхийн үнийн саналыг албажуулан ирүүлэхээр болсон юм.<br>- Эрээн хотын барилгын захуудаар улирлын чанартай үнэ хэлбэлздэг барилгын материалын үнийн судалгааг хийж, нэгтгэн хянаж, 88 барааны үнийг шинэчлэн CAIS системийн “хил орчмын үнийн судалгаа” хэсэгт байршуулан, 2024 оны 06 дугаар сарын | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 04-ний өдрөөс эхлэн үнийн хяналтын зорилгоор ашиглаж байна.<br><br>3. CAIS системийн "Эрсдэлийн удирдлагын програм"-д "гаалийн нутаг дэвсгэрт чөлөөт эргэлтэд байгаа монголын барааг хилийн чанадад бүрмөсөн гаргах горим"-той, БТКУС-ийн Зүйл 27.01, 27.02 кодод хамаарах нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүн, 26.01 кодод хамаарах төмрийн хүдэр, төмрийн баяжмалын гаалийн бүрдүүлэлтэд "биржийн гэрээ"-тэй гэж мэдүүлсэн тохиолдолд гаалийн хяналтын ногоон төлөвт оруулах саналыг ЭУХ-т, МТГ-т биржтэй гэж мэдүүлсэн бол програмаас ББ ГУБ томилохгүйгээр хэлцлийн үнийн аргаар автоматаар үнэлэх саналыг өгч, МТГ-ын дарга, ГУАБ-тай уулзалт хийж, програмын аргаар шийдэх боломжтой тул 2025 онд хэрэгжүүлэхээр болсон. | | |
| Зорилт 3: Улсын төсвийн орлогыг шударга, үр ашигтай, үр дүнтэй бүрдүүлэх | | | | | | | |
| 9. | 3.1.Улсын төсвийн гаалийн орлогыг хууль тогтоомжийн хүрээнд үр дүнтэй бүрдүүлэх | Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт төгрөгөөр, хувиар | Гаалийн байгууллага нь 2023 онд 5720.5 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 5327.2 тэрбум төгрөг оруулж, 93.1 хувь байна.<br>-Татварын орлого 5,173.8 тэрбум төгрөг,<br>-Хураамжийн орлого 123.5 тэрбум төгрөг, | Төсвийн тухай хуульд заасан гаалийн байгууллагын улсын төсөвт оруулах 6727.9 тэрбум төгрөгийн орлогын төлөвлөгөөг биелүүлсэн байна. Гүйцэтгэл 100 хувьтай байна. | Гаалийн байгууллагын төсвийн нийт орлого 2024 онд 6727.9 тэрбум төгрөг улсын төсөвт төвлөрүүлэх үүрэг хүлээсэн.<br>2024 оны 11 дүгээр сарын 30-ний өдрийн байдлаар өссөн дүнгээр 6256.1 тэрбум төгрөг, төвлөрүүлэхээс 6113.0 тэрбум төгрөг төврөлүүлж 97.7 хувийн биелэлттэй байна.<br>Өмнөх оны мөн үед улсын төсвийн нийт орлого 4815.5 тэрбум төгрөг төвлөрүүлж 93.2 хувийн биелэлттэй байсан байна. Улсын төсийн нийт орлогын биелэлтийг өмнөх онтой харьцуулахад 1297.5 тэрбум төгрөгөөр буюу 26.9 хувиар өссөн үзүүлттэй байна. Биелэлтийн хувь мөн 4.5 функтээр өссөн байна. Үүнээс:<br>- Татварын орлогоор 6119.1 тэрбум төгрөг улсын төсөвт төвлөрүүлэхээс тайлант хугацаанд 2024 оны 11 сарын 30-ны өдрийн | 2024.01.01<br>-<br>2024.11.30 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | -Өөрийн орлого 29.97 тэрбум төгрөг. | | байдлаар 5968.1 тэрбум төгрөг төвлөрүүлж 97.5 хувийн биелэлттэй байна. Өмнөх оны мөн үед 4674.9 тэрбум төгрөгт төвлөрүүлж 91.9 хувийн биелэлттэй байсан байна. Өмнөх онтой тайлант хугацааны татварын орлогыг харьцуулахад 1293.2 тэрбум төгрөгөөр их буюу 27.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Биелэлтийн хувь мөн 5.6 функтээр өссөн байна.<br>- Хураамжийн орлого 2024 онд 135.0 тэрбум төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөтэй. 2024 оны 11 сарын байдлаар 122.7 тэрбумын орлого төвлөрүүлэхээс 132.5 тэрбумын орлого төвлөрүүлж 108.0 хувийн гүйцэтгэлтэй байна. Өмнөх оны мөн үед төвлөрүүлсэн 112.5 тэрбум төгрөгтэй харьцуулахад 20.0 тэрбум төгрөгөөр их буюу 17.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.<br>- Өөрийн орлого 15.0 тэрбумын төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 2024 оны 11 сарын байдлаар 14.1 тэрбумын орлого төвлөрүүлэх төлөвлөгөөтэй. Тайлант хугацаанд буюу 11 сарын 30-ны байдлаар 12.4 тэрбумын орлого төвлөрүүлж 87 хувийн биелэлтэй байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад өөрийн орлого 15.6 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлттэй байна. Энэ нь Бүрдүүлэлтийн дараах шалгалтын газрын 2024 онд Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө тасарч байгаатай холбоотой. Тодруулбал 2024 оны 1 дүгээр сараас эхлэн прокурорын байгууллагаас бүрдүүлэлтийн дараах шалгалтын акт нь 50 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй бол цагдаагийн байгууллага руу шилжүүлж, шалгалтын үйл ажиллагаа явуулах шаардлагыг тавьж эхэлсэнтэй холбоотой. Ингэснээр БДШГ-ын төлбөрийн актын биелэлт удааширч орлогын төлөвлөгөө тасарсан байна. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | **Үр дүн:** Тайлант хугацаанд буюу 2024 онд 6792.9 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс Улсын төсөвт нийт 6798.0 тэрбум төгрөгийг төвлөрүүлж 100.1 хувийн биелэлттэй байна. Орлогын төлөвлөгөөний биелэлт тус бүрээр авч үзвэл.<br>- татварын орлого 6642.9 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 6641.0 тэрбум төгрөг, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 27.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.<br>- хураамжийн орлого 135.0 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 144.1 тэрбум төгрөг, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 17.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.<br>- өөрийн орлого 15.0 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 13.8 тэрбум төгрөг тус тус төвлөрүүлж,<br>Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 1470.1 тэрбум төгрөг буюу 28 хувиар илүү төвлөрүүлсэн. | | |
| 10. | 3.3."Чөлөөт худалдааны хэлэлцээр" байгуулах талаар судалгаанд оролцох | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Монгол Улс, БНСУ хооронд ЭЗТХ байгуулах ажлын хэсэг болон 14 дэд бүлэгт гаалийн байгууллагын төлөөлөгчид оролцсон.<br>БНСУ-ын Сөүл хотноо 2023 оны 12 дугаар сарын 18-20-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Монгол Улс, БНСУ хоорондын ЭЗТХ-ийн эхний шатны хэлэлцээнд ГЕГ- | Монгол Улс, БНСУ хооронд ЭЗТХ байгуулах дараагийн хэлэлцээрт оролцох бэлтгэл ажлыг хангаж, оролцсон байна. | Монгол Улс, Солонгос Улс хоорондын Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулах хэлэлцээний багт Эдийн Засаг хөгжлийн яамны төрийн нарийн бичгийн даргын 2024-09-05 өдрийн А/207 дугаар тушаалаар батлагдсан бүлгийн ажлын хэсэгт гаалийн байгууллагаас дараах 10 бүлэгт оролцон ажиллаж байна. Үүнд:<br>• БАРААНЫ ХУДАЛДАА<br>• ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУДАЛДАА<br>• БАРААНЫ ГАРАЛ ҮҮСЭЛ<br>• ГААЛИЙН ЖУРАМ БА ХУДАЛДААГ ХӨНГӨВЧЛӨХ<br>• ХУДАЛДААН ДАХЬ ТЕХНИКИЙН СААД ТОТГОР<br>• ЭРҮҮЛ АХУЙ, УРГАМЛЫН ЭРҮҮЛ АХУЙ АРГА ХЭМЖЭЭ | 2024.01.01 - 2024.11.30 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | аас 5 албан хаагч оролцсон. | | • ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА<br>• ОЮУНЫ ӨМЧИЙН ЭРХ, БАЙГАЛЬ ОРЧИН<br>• ЦАХИМ ХУДАЛДАА<br>• ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН БОЛОН ИНСТИТУЦЫН АСУУДАЛ<br><br>***Монгол Улс, Солонгос Улс хоорондын Эдийн засгийн түншлэлийн эхний хэлэлцээ***: БНСУ-д 2023 оны 12 дугаар сарын 18-20-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, түүний мөрөөр Ажлын хэсгийн үр дүнгийн уулзалтыг ЭЗХЯ-нд 2024 оны 01 дүгээр сарын 17-19-ний өдрүүдэд анхны хэлэлцээний үр дүн, цаашид хэрэгжүүлэх ажлыг ярилцах хурлыг 14 бүлгийн хүрээнд зохион байгуулсан. Бизнесийн төлөөлөлтэй 2024 оны 05 дугаар сарын 09-ны өдөр МҮХАҮТ дээр уулзалт зохион байгуулж, хоёр талын худалдааг харилцан ашигтай, бизнес эрхлэгч, үйлдвэрлэгчдийг дэмжих боломжийн талаар санал солилцсон.<br>***Хоёр дахь шатны хэлэлцээ:*** МУ-д УБ хотноо 2024 оны 05 дугаар сарын 21-23-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдаж, хэлэлцээний үр дүнгийн хуралд хоёр талаас тав, таван бүлэг Хоёр дахь шатны хэлэлцээний үр дүнг танилцуулж,<br>***Гурав дахь шатны хэлэлцээ:*** МУ-д УБ хотноо 2024 оны 09 дүгээр сарын 10-13-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдсан. Монгол Улсын Засгийн газрын шинэчлэн байгуулагдсантай уялдан албан тушаал нь өөрчлөгдсөн болон шинээр нэмэх бүлгийн ажлын гишүүдийн мэдээллийг Холбогдох яам, агентлагаас санал авч Гурав дахь шатны хэлэлцээ эхлэхээс өмнө шинэчлэн баталсан.<br>***Дөрөв дэх шатны хэлэлцээ:*** БНСУ-д 2024 оны 11 дүгээр сарын 26-29-ны өдрүүдэд зохион байгуулагдсан. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт 4: “Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх” | | | | | | | |
| 11. | 4.1.Дэлхийн худалдааны байгууллагын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр, Монгол Улсын Япон Улстай байгуулсан эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр, 2017 онд шинэчлэн батлагдсан Төрийн албан тухай хууль, 2019 онд батлагдсан Татварын ерөнхий хууль болон бусад хууль тогтоомжтой нийцүүлэн "Гаалийн тухай хууль"-ийн шинэчилсэн найруулгын төсөл, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хурлаар батлуулах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 1.Гаалийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлаар батлуулахаар Сангийн яаманд хүргүүлсэн. | 1.Гаалийн тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулиудыг батлуулах арга хэмжээг авсан байна.<br>2.Гаалийн тухай хууль болон Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн төсөлд нийцүүлэн журам, заавруудыг боловсруулсан байна. | **1.** “Ажлын хэсэг байгуулах тухай” ГЕГ-ын даргын 2023 оны №А/03 тушаалаар батлагдсан Гаалийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалын төсөл, Гаалийн тариф, татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалын төсөл, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсэгт 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрөөс 2023 оны 3 дугаар сарын 15-ны өдрүүдэд ажилласан. Энэ хугацаанд 2021-2023 онд шинээр батлагдсан Зөвшөөрлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжуудад орсон өөрчлөлтүүдийг судалж, хуулийн төслийг нийцүүлсэн. Мөн гаалийн байгууллагын чиг үүрэгт шинээр орсон хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт, шалгалтын асуудлыг шинээр бүлэг болгон Гаалийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгасан. Түүнчлэн гадаад улсуудын жишиг, УИХ-ын гишүүдтэй хийсэн уулзалт дээр өгсөн чиглэлийн дагуу Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн төслийг Гаалийн тухай хуулийн төсөлд нэгтгэн найруулав.<br>Гаалийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг шинэчлэн найруулсан.<br>Хуулийн төслийн холбогдох заалтуудыг боловсруулах үед ГЕГ-ын холбогдох бүтцийн нэгжүүдтэй хамтран ажиллаж, гарч буй хүндрэл, хуулиар зохицуулах шаардлагатай байгаа асуудлууд, худалдаа хөнгөвчлөх, үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр хийгдэж байгаа ажлуудын талаар ярилцаж саналуудыг тусган ажилласан болно. | 2024.01.01<br>-<br>2024.11.30 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Хуулийн төслүүд, үзэл баримтлалыг "Санал шийдвэрлүүлэх тухай" Гаалийн ерөнхий газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 01/2842 албан бичгээр Сангийн сайд Б.Жавхланд хүргүүлсэн болно.<br>Гаалийн ерөнхий газрын даргын тушаалаар батлагдсан ажлын хэсэг нь Гаалийн тухай хууль, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль, Амьтан ургамал тэдгээрийн гаралтай түүхий эдийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналтын тухай хуулийн гаалийн байгууллага хэрэгжүүлэн ажиллах холбогдох заалтуудыг тусган хуулийн төсөл боловсруулсан.<br>Хуулийн төсөл Ерөнхий зүйл, Мэдээлэл, зөвлөгөө, лавлагаа, гомдол, Гаалийн тариф, барааны үнэ, ангилал, гарал үүслийг тодорхойлох, гаалийн болон бусад татвар ногдуулах, хураах, төлөх, Гаалийн хяналт, бүрдүүлэлт, Гаалийн бүрдүүлэлтийн горим, Гаалийн албаны тогтолцоо зэрэг зургаан хэсгээс бүрдсэн харилцааг зохицуулсан.<br>Гаалийн ерөнхий газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн "Санал шийдвэрлүүлэх тухай" 01/2842 дугаар албан бичгээр Сангийн сайд Б.Жавхланд хүргүүлэн ажиллалсан. | | |
| 12. | 4.3.Гаалийн төв болон салбар лабораторийг олон улсын жишигт нийцүүлэх | Хэрэгжилт, хувиар | 1.Гаалийн төв лабораторийг эрдэс түүхий эд, нүүрс, газрын тосны бүтээгдэхүүний шинжилгээний чиглэлээр Олон улсын итгэмжлэлд хамруулах ажлын | 1.Замын-Үүд дэх гаалийн газрын салбар лабораторийг нефтийн бүтээгдэхүүн, ноос ноолуурын шинжилгээний чиглэлээр, Дорнод аймаг дахь | Гаалийн төв лаборатори нь БНХАУ-ын итгэмжлэлийн үнэлгээний байгууллага CNAS-ийн төлөвлөгөөний дагуу 2024 онд хяналтын шатны үнэлгээнд амжилттай хамрагдаж, уул уурхайн эрдэс түүхий эд, нүүрс, газрын тосны бүтээгдэхүүний магадлан шинжилгээний чиглэлээр итгэмжлэлийн эрхээ 2025 он хүртэл амжилттай сунгасан.<br>2) Гаалийн салбар лабораториудыг Үндэсний итгэмжлэлд хамруулах бэлтгэл | 2024.01.01 - 2024.11.30 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хүрээнд БНХАУ-ын итгэмжлэлийн үнэлгээний байгууллага/CNAS/-ын цахим үнэлгээнд амжилттай хамрагдаж, эрдсийн бүтээгдэхүүнд 14 үзүүлэлтээр, нүүрсэн бүтээгдэхүүнд 8 үзүүлэлтээр, газрын тосны бүтээгдэхүүнд 19 үзүүлэлтээр итгэмжлэхээр шийдвэрлэсэн.<br>2.Гаалийн лабораторийн тоног төхөөрөмжийн шинжилгээний үр дүнг цахим хэлбэрт шилжүүлэх “Лабораторийн мэдээллийн менежментийн систем” /LIMS/-ийг гаалийн төв лабораторийн үйл ажиллагаанд нэвтрүүлсэн. | гаалийн газрын салбар лабораторийг хими, нефтийн шинжилгээний чиглэлээр итгэмжлэлийн хүрээг өргөтгөж, Сэлэнгэ аймаг дахь гаалийн газрын Гаалийн салбар лабораторийг согтууруулах ундаа, химиí, нефтийн бүтээгдэхүүний шинжилгээний чиглэлээр, Гашуунсухайт, Шивээхүрэн, боомтуудын салбар лабораториудыг нүүрсний чиглэлээр, Увс аймаг дахь гаалийн газрын Боршоо боомтын салбар лабораторийг нефтийн чиглэлээр дотоодын итгэмжлэлд хамруулсан байна.<br>2.Гаалийн лабораторийн тоног төхөөрөмжийн | ажлыг хангах хүрээнд СЭГГ, ЗҮГГ, ОРГГ, БӨГГ, СШГГ-ын гаалийн салбар лабораториудад MNS ISO/IEC 17025:2018 “Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавих ерөнхий шаардлага” стандартын дагуу дотоод аудит хийж, илэрсэн үл тохирлыг залруулах арга хэмжээ авч ажиллан, “Салбар лабораторийн үйл ажиллагааны дотоод журам”-уудыг хянаж, засварлан, тухайн гаалийн газрын удирдлагаар батлуулснаар Үндэсний итгэмжлэлд хамруулах бэлтгэл ажил хангагдсан.<br>3) ЗҮГГ, ОРГГ, СШГГ-ын салбар лабораториуд итгэмжлэлд хамрагдах тухай өргөдөлийг холбогдох бичиг баримтын хамтаар Үндэсний итгэмжлэлийн төвд хүргүүлээд байна.<br>4) Дорнод аймаг болон ГСГГ-ын Оюутолгой дах салбар лабораториудын хувьд магадлан шинжилгээний нөхцлийн дагуу лабораторийн барилгад агааржуулалтын засвар үйлчилгээний ажил явагдаж байсан тул газар дээр нь аудит хийх боломжгүйгээс түр хугацаагаар хойшлуулан байна.<br>- ХоГГ болон УвГГ-ын салбар лабораториудад боловсон хүчний дутагдалтай байгаагаас шалтгаалан хийгдэж буй шинжилгээг бүрэн явуулах боломж бүрдэхгүй байгаа тул 2025 онд дотоод аудит хийж, Үндэсний итгэмжлэлд хамруулахаар хойшлуулсан.<br>ЧХОУНБГГ-ын салбар лабораторийг химийн бодис, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис, хүнсний бүтээгдэхүүний шинжилгээний чиглэлээр 30 тоног төхөөрөмжүүдийг нийлүүлэгч компаниуд суурилуулан, тохиргоо хийж, сургалт явуулж хэвийн ажиллагаанд оруулсан. Барилгын засвар бүрэн дуусаагүй.<br>- ГСГГ-ын ГСЛ-ийг 2024.9 сард хүлээн авч, хорио цээрийн шинжилгээний 23 багажийг | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | шинжилгээний үр дүнг цахим хэлбэрт шилжүүлэх | суурилуулсан. МАК-ГЕГ-тай хийсэн гэрээний дагуу ШХГГ-т ГСЛ-д хэвийн ажиллагаанд оруулж, 183 дээжинд шинжилгээ хийж, 31,1 сая төг оруулсан.<br>- УвГГ-ын ГСЛ-д 222 дээж шинжилж, 5,184 сая төг оруулсан.<br>- ЗҮГГ, СЭГГ-ын салбар лабораториудад LIMS-ийг бүрэн нэвтрүүлсэн. | | |
| 13. | 4.7.Эрэлч нохойн сургалтын төвийн үйл ажиллагааг өргөжүүлэх, албаны эрэлч нохойн ашиглалтыг нэмэгдүүлэх | Эрэлч нохойн тоо, Эрэлч нохой хариуцсан гаалийн улсын байцаагчийн тоо, Илрүүлсэн зөрчлийн тоо, хувиар | 1. Эрэлч нохойн тоог 5-аар нэмэгдүүлж, нийт 48 эрэлч нохойтой<br>2. Гаалийн ерөнхий газрын харьяа 11 газар хороодод 28 эрэлч нохой хариуцсан гаалийн улсын байцаагч эрэлч нохойн хамтаар ажиллаж байна.<br>3. Эрэлч нохой хариуцсан гаалийн улсын байцаагч нарын тоог 5 хувиар нэмэгдүүлж ажилласны үр дүнд албаны эрэлч нохойг ашиглан 20 зөрчил илрүүлэн ажилласан. | 1.Эрэлч нохойн тоог 5-аар нэмэгдүүлж, нийт 49 эрэлч нохойтой болно.<br>2. Эрэлч нохой хариуцсан гаалийн улсын байцаагчийн тоог 5-аар нэмэгдүүлж, сургана.<br>3. Эрэлч нохойг гаалийн хяналт, шалгалтад ашиглаж, зөрчил илрүүлэлтийг өмнөх оны мөн үеэс 5 хувиар нэмэгдүүлнэ. | 2024 оны жилийн эцсийн байдлаар 13 газар хороодод 33 эрэлч нохой ажиллаж 38 зөрчил илрүүлсэн. Энэ нь 2023 оны жилийн эцэстэй харьцуулан үзэхэд 90%-иар өссөн үзүүлэлттэй байна. Эрэлч нохдын зөрчил илрүүлэх чадварыг дээшлүүлэх, гаалийн хяналт шалгалтад ашиглах эрэлч нохдыг нэмэх зорилгоор хориглосон хязгаарласан бараа бүтээгдэхүүн, хар тамхи мансууруулах бодис зэргийг таньж илрүүлэх ЭНСТ-ийн анхан болон давтан сургалтуудад хамрагдаж бэлтгэгдсэн 14 нохойгоор нэмэгдүүлсэн. Үүнд: ЧХОУНБГГ-т 3 нохой, ДоГГ-т 2 нохой, СшГГ-т 1 нохой, ЗүГГ-т 2 нохой, УБГГ-т 1 нохой, УвГГ-1 нохой ЭНСТ-4 нохойгоор тус тус нөхөн хангалт хийсэн.<br>2024 онд эрэлч нохойн сургалтын төвийн даргын баталсан сургалтын хөтөлбөрүүдийн дагуу 7 удаагийн сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор гаалийн байгууллагын 52 албан хаагчийг хамруулан ажилласан. Гаалийн ерөнхий газрын харьяа 13 газар хороодод эрэлч нохойн чиглэлээр ажиллаж байгаа гаалийн улсын ахлах байцаагч 3, гаалийн улсын байцаагч 27, эрэлч нохой хариуцагч 3 нийт 35 албан хаагч, эрэлч нохойн сургалтын төвийн 3 албан хаагчийг эрэлч нохойн танхимын болон цахим сургалтад 100 хувь хамруулсан. 2024 онд 5 удаа сургалт зохион байгуулахаар гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулсан, биелэлтээр 7 | 2024.01.01<br>-<br>2024.11.30 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | удаагийн сургалт зохион байгуулсан нь 40 хувиар өссөн үзүүлэлт болсон. Сургалтын тоо өсөх болсон шалтгаан нь 2023 оны 12-р сар болон 2024 онд шинээр томилогдсон эрэлч нохой хариуцсан ГУБ нартай холбоотой байна. | | |
| 14. | 4.15.Автозамын хилийн боомтуудын хилээр нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, дэд бүтцийг өргөтгөн шинэчлэх | Хэрэгжилт, хувиар | 1.Алтанбулаг боомтын бүтээн байгуулалтын барилга байгууламж, автозам зогсоолын барилгын ажлын нийт гүйцэтгэл 92%-тай. Улсын комисс 2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр, 1-р ээлжийн барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авсан.<br>2.Бичигт боомтын авто замын барилгын ажлын гүйцэтгэл 25%, барилга байгууламжийн ажлын гүйцэтгэл 5%.<br>3.Гашуунсухайт боомтын бүтээн байгуулалтын барилгын ажил 64.8%-ийн гүйцэтгэлтэй. | 1.Алтанбулаг боомтын бүтээн байгуулалтын барилгын ажил 100%-д хүрч дуусна. Боомтын барилгын дотоод тохижилт, хаягжилт, тэмдэг, тэмдэглэгээ, тоноглол, гаалийн хяналт шалгалтын зарим тоног төхөөрөмжийг суурилуулж ашиглалтад хүлээж авах ажлыг зохион байгуулсан байна.<br>2.Бичигт боомтын бүтээн байгуулалтын барилгын ажил 50%-д хүрсэн байна.<br>3.Гашуунсухайт боомтын бүтээн байгуулалтын барилгын ажил 100%-д хүрч дуусна. Боомтын барилгын дотоод тохижилт, | 1. Монкон ХХК-иас бүтээн байгуулалтын төслийн гэрээний хугацаа болон нэмэлт санхүүжилтийг шийдвэрлээгүй зэрэг асуудлуудыг үндэслэл болгон 2024.05.12-ны өдрөөс 2-р ээлжийн барилгын ажлыг зогсоосон. Боомтын доторх 2-р ээлжийн зам талбайн ажлыг 2024.07.24-нд Улсын комисс хүлээн авсан. Гүйцэтгэл 100%.<br>2. Бичигт боомтын авто замын ажил 25%, барилгын ажил 10%. Бичигт боомтын ой хээрийн түймэр, гадаргын ус зайлуулах зураг төслийг хянаж баталсан.<br>3.Гашуунсухайт боомтын бүтээн байгуулалтын гүйцэтгэл 100% хийгдэж, барилга байгууламж, зам талбайн ажлыг Улсын комисс 2024.07.05-ны өдөр хүлээн авч ашиглалтад оруулсан. Гашуунсухайт боомтоор 2019 онд 20.5 сая тн нүүрс, 763 мянган тн зэсийн баяжмал экспортод гарч байсан бол бүтээн байгуулалт хийгдсэний дараа 2024 оны эхний 11 сард 35.7 сая тн нүүрс, 909 мянган тн зэсийн баяжмал экспортолсон байна. Үүнийг харьцуулж үзвэл нүүрсний экспорт 75 хувиар, зэсийн баяжмалын экспорт 19 хувиар тус тус өссөн байна.<br>4."Хөгжлийн хөтөч-Дэд бүтэц" төслийн хүрээнд Шивээхүрэн боомтыг хөгжүүлэх хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг төсөл боловсруулах ажил бүрэн хийгдэж дууссан. Гүйцэтгэл 100%. Боомтын бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалт 2024 онд шийдэгдээгүй байна. | 2024.01.01<br>-<br>2024.11.30 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 4. Шивээхүрэн, боомтын ТЭЗҮ, БОТБҮ, нарийвчилсан зураг төслийн ажил 100%-д хүрсэн.<br>5.ЭЗХЯ-ны захиалгаар ТХААГ-аас Эрээнцав, Арцсуурь боомтын ТЭЗҮ, нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын тендер зарлагдаж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан. Зураг төслийн ажлын явц Эрээнцав боомт 30%, Арцсуурь боомт 45%-ын гүйцэтгэлтэй.<br>6.Гашуунсухайт боомтод ухаалаг гарцын тоног төхөөрөмж суурилуулах ажлыг бүтээн байгуулалттай уялдуулан гүйцэтгэж байна. Гүйцэтгэл 35% байна. Боршоо, Алтанбулаг боомтод | хаягжилт, тэмдэг, тэмдэглэгээ, тоноглол, гаалийн хяналт шалгалтын зарим тоног төхөөрөмжийг суурилуулж ашиглалтад хүлээж авах ажлыг зохион байгуулсан байна.<br>4.Шивээхүрэн боомтын бүтээн байгуулалтын барилгын ажлыг эхлүүлсэн байна.<br>5.Даян, Байтаг, Тэс, Арцсуурь, Эрээнцав, Бага-Илэнх, Зэлтэр боомтуудыг хөгжүүлэх, дэд бүтцийг өргөтгөж шинэчлэх хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний нарийвчилсан зураг төслийн ажлын даалгаварт тусгах саналыг боловсруулан гүйцэтгэгч байгууллагад өгч хамтран ажилласан байна. Зураг төсөл Барилгын хөгжлийн төвөөр | 5.Арцсуурь боомтын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний нарийвчилсан зураг төсөлд барилга байгууламж, авто зам, гаалийн хяналт шалгалтын тоног төхөөрөмжийн байршлыг тусгуулж, хянаж зөвшилцсөн. Арцсуурь боомтын зураг төсөл БХТ-өөр хянагдаж баталгаажсан бөгөөд төсөв хянагдаж байна. Гүйцэтгэл 98%.<br>Даян, Бага-Илэнх боомтуудыг хөгжүүлэх хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг төсөл боловсруулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг ЭЗХЯ-ны захиалгаар ТХААГ-аас зарласан.<br>Эрээнцав боомтын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг төсөлтэй танилцаж, холбогдох саналыг гүйцэтгэгчид өгсөн. Саналын дагуу гүйцэтгэгчээс өөрчлөлтийг хийж зургаа дахин танилцуулсан бөгөөд зураг төслийг хянаж баталгаажуулсан. Эрээнцав боомтын ТЭЗҮ, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг төсөл БХТ-өөр хянуулахад бэлэн болсон. Гүйцэтгэл 70%.<br>6.Замын-Үүд, Гашуунсухайт, Ханги боомтуудад ухаалаг гарцуудыг суурилуулсан. Гүйцэтгэл 100%<br>Баянхошуу боомтод ухаалаг гарцын тоног төхөөрөмж суурилуулалтын ажил санхүүжилттэй холбоотойгоор 2025 онд хийгдэхээр болсон.<br>Алтанбулаг, Боршоо боомтуудад суурилуулах ухаалаг гарцын тоног төхөөрөмжийн тендер шалгаруулалт зарлах зөвшөөрөл АХБ-наас RIBS төслийн нэгж дээр хүлээгдэж байна.<br>7.Цагаандэл уул боомтын зураг төсөл болон төсвийг 2 үе шатанд хувааж хийхээр өөрчлөлт оруулсан. Эхний шатны зураг төслийн ажлын даалгаврыг хянаж, баталгаажуулсан. Гүйцэтгэл 92%. Боомтын ТЭЗҮ БХТ-ийн магадлалаар хянагдаж баталгаажсан. Гүйцэтгэл 100%. Бэлтгэл ажлын хүрээнд | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | суурилуулах ухаалаг гарцын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зарлагдсан ба эцэслэгдээгүй байна. Ханги боомтод ухаалаг гарцын тоног төхөөрөмж суурилуулахаар байршлыг тодорхойлохоор ажлыг хэсэг газар дээр нь ажиллаж санал боловсруулсан.<br>7.Цагаандэл уул боомтын зураг төслийн ажлын гүйцэтгэл 85%-тай. Боомтын түр гарц нээж гадна хашаа барих ажлын явц 90%-ийн гүйцэтгэлтэй. | баталгаажсан байна.<br>6.Алтанбулаг, Баянхошуу, Гашуунсухайт боомтуудад ухаалаг гарцын системийг нэвтрүүлсэн байна.<br>7.Цагаандэл уул боомтын БНХАУ-ын ӨМӨЗО-ны Альшаа аймгийн буцалтгүй тусламжаар бүтээн байгуулах төсөл хэрэгжүүлэх гэрээг шинэчлэн байгуулсан тохиолдолд түр гарц нээх, барилгын ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангасан байна. | боомтын түр гарц нээж гадна хашаа барих ажил 100% хийгдсэн.<br>Ухаалаг гарцын системийн тоног төхөөрөмж: Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа гаалийн шинэчлэлийн хүрээнд боомт руу орох, гарах хаалга болон боомт доторх замын эгнээнүүд дээр RFID-г суурилуулж, боомтын тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналтыг сайжруулахаар ажиллаж байна.<br>1.Гашуунсухайт боомтын нүүрсний терминалын экспортын хэсгийн 4, импортын хэсгийн 3 эгнээ замд тус бүрт нь RFID-г түр суурилуулан 2023.02.17-ны өдрөөс эхлэн өдөртөө хилээр гарч байгаа нүүрс ачсан тээврийн хэрэгслүүдийг бүртгэсэн. Тус боомтын шинэчлэл, бүтээн байгуулалтын ажилтай холбоотойгоор өнөөдрийн байдлаар нүүрсний гарах хэсэгт хяналтын бүсрүү орох 2, хяналт шалгалтын саравч доор суурилуулсан 4 ухаалаг гарцыг тогтмол ашиглаж байна. Гашуунсухайт боомтод 2024.11.30-ны өдрийн байдлаар нүүрсний терминалын 35, зорчигчийн терминалын 20, зэсийн баяжмалын хэсэгт 4 буюу нийт 59 эгнээ, замд RFID-г суурилуулахаас 57 гарцад суурилуулсан төхөөрөмжийг гүйцэтгэгч компаниас хүлээж авсан. Хилээр гарах талын рентген, дээж авагчийн ухаалга гарцын ажил нь хүлээгдэж байна.<br>2.Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл /RIBS/-ийн хүрээнд АХБ-аас зохион байгуулах Алтанбулаг боомтод суурилуулах ухаалаг гарцын тоног төхөөрөмж нийлүүлэх багцын тендер сонгон шалгаруулалтын ажил хүлээгдэж байна.<br>3.Баянхошуу боомтын техник эдийн засгийн үндэслэлийн /ТЭЗҮ/ тайлан магадлалаар хянагдаж баталгаажсан, төсөв нь | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | экспертизээр хянагдаж байна. Тус боомтод суурилуулах ухаалаг гарцын тоног төхөөрөмжийн байршлыг тодорхойлохоор ГЕГ-аас 2024 оны 12 дугаар сард ажлын хэсэг ажиллахаар төлөвлөсөн байсан боловч хойшлогдсон.<br><br>ХҮРСЭН ҮР ДҮН:<br>1.Гашуунсухайт боомтод 2024.12.15-ны өдрийн байдлаар нүүрс, зорчигч, зэсийн баяжмалын хэсэгт нийт 59 эгнээ, замд RFID-г суурилуулахаас 57 гарцад суурилуулсан төхөөрөмжийг гүйцэтгэгч компаниас хүлээж авсан. Гашуунсухайт боомтын нүүрсний терминалын 7 эгнээ замд тус бүрт нь RFID-г түр суурилуулан хилээр гарч байгаа нүүрс ачсан тээврийн хэрэгслүүдийг бүртгэж байна.<br>2.Алтанбулаг боомтод RFID суурилуулах ажлыг RIBS төслөөс хэрэгжүүлэх тендер, сонгон шалгаруулалт хүлээгдэж байна. Иймд энэ ажлын гүйцэтгэл нь гаалийн байгууллагаас шалтгаалахгүй.<br>3.Баянхошуу боомтод RFID суурилуулах ажлыг тус боомтын бүтээн байгуулалтын явцтай уялдуулах учраас гүйцэтгэл нь гаалийн байгууллагаас шалтгаалахгүй. | | |
| 15. | 4.16.Гаалийн төв болон салбар лабораторийн чадавхыг бэхжүүлэх | Дээжийн тоо, хувиар, Магадлан шинжилгээнд зарцуулах хугацаа, хоногоор | ."Чингис хаан" олон улсын нисэх буудал дахь гаалийн газрын салбар лаборатори болон Увс аймгийн Боршоо дахь гаалийн салбар лабораториудыг хэвийн үйл ажиллагаанд | 1.Булган, Цагаандэл-Уул, Бургастай боомтод шинээр салбар лабораторийг байгуулан нүүрс, эрдэс түүхий эдийн шинжилгээний тоног төхөөрөмжийг суурилуулж, үйл | 1. ЧХОУНБГГ, УвГГ, ХоГГ, ШХГГ-ын салбар лабораториудыг шинээр байгуулж, хэвийн үйл ажиллагаанд оруулан, 408 дээжид магадлан шинжилгээг хийснээр магадлан шинжилгээнд хамрагдах хугацааг 1-3 хоногоор бууруулсан.<br>2.ГТЛ, ЧХОУНБГГ, УвГГ, ХоГГ, СЭГГ, ГСГГ, ЗҮГГ-ын салбар лабораториудад хүнсний эрүүл ахуй, хорио цээрийн шинжилгээ хийх нөхцөл бүрдүүлж, 16298 дээжинд шинжилгээ хийсэн нь нийт дээжний 41,2%-д ээлж байна.<br>3. ХоГГ, СЭГГ, ГСГГ, ЗҮГГ, ШХГГ, ДоГГ-ын салбар лабораторийн барилгын зураг төсөлд шинжилгээний чиглэлээс хамааран орох | 2024.01.01 - 2024.11.30 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | оруулж эхлүүлж ажилласан.<br>3.Гаалийн төв лаборатори болон Баян-Өлгий аймаг дахь Гаалийн газрын Цагаан нуур дахь салбар лабораторид хорио цээрийн шинжилгээг нэвтрүүлсэн. | ажиллагаанд оруулснаар магадлан шинжилгээнд хамрагдах нийт дээжийн тоог 5-10 хувиар нэмэгдүүлнэ.<br>2.Булган, Цагаандэл-Уул, Бургастай боомтод шинээр салбар лабораторийг байгуулснаар тус гаалийн газрын хяналтад байгаа барааны магадлан шинжилгээнд хамрагдах хугацааг 3-4 хоногоор бууруулна.<br>3.Гаалийн төв лабораторид импортын зарим хүнсний бүтээгдэхүүнд нян судлал, хор судлал, ургамлын хорио цээрийн шинжилгээ хийж эхэлнэ. | өөрчлөлтийг тусган, холбогдох мэдээллийн хамт боомтын хэлтэс болон харьяа гаалийн газар, хороодод хүргүүлсэн.<br>- СЭГГ-ын ГСЛ-ийн барилгыг тодорхой үүрэг даалгавартайгаар улсын комисс хүлээн авсан, гүйцэтгэл 90%.<br>- ХоГГ-ын ГСЛ-ийн барилгын зураг төслийн дагуу засвар хийх тендер зарласан боловч амжилтгүй болсон.<br>- ЗҮГГ болон ДОГГ-ын ГСЛ-ийн барилыгн зураг төслийн өөрчлөлтийг оруулж, 2025 оны хийхээр хөрөнгө орулалтад тусгасан. ГСГГ болон ШХГГ-ын салбар лабораторийн барилгын зураг төсөл, холбогдох мэдээллийг гаргаж, ҮБХГ-т хүргүүлж, санхүүжилтыг 2025 онд шийдвэрлэхээр тусгасан.<br>- Боомтын бүтээн байгуулалттай уялдуулан Булган, Цагаандэл-Уул, Бургастай боомтод шинээр салбар лабораторийг байгуулах ажил хойшлогдоод байна.<br>ГТЛ-иос СЭГГ, ЗҮГГ, ОРГГ, СШГГ-ын салбар лабораториудад дотоод аудит хийж, илэрсэн үл тохиролыг залруулан ажиллах хугацаатай үүрэг даалгавар өгч, ирүүлсэн тайланг хянаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.<br>Гаалийн лабораториудын магадлан шинжилгээний үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлж, шинжилгээний тоног төхөөрөмжийн үр дүнг лабораторийн мэдээллийн менежментийн систем (LIMS)-д холбог ажлыг 2024 онд ЧХОУНБГГ, БӨГГ, ДОГГ, СШГГ, ОрГГ, СЭГГ, ГСГГ-ОТ, ЗҮГГ-ын салбар лабораториудад нэвтрүүлж дууссанаар шинжилгээни явц дээр бүрэн хяналт тавих боломж бүрдсэн.<br>Гаалийн төв болон салбар лабораториудад нийт магадлан шинжилгээнд ирүүлсэн дээжний 93% буюу 36793 дээжийг шинжилснээр дээжний тоо өмнөх онтой харьцуулахад 22,3%-иар нэмэгдэн, магадлан | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шинжилгээнд хамруулах хугацааг 2-3 хоногоор бууруулсан. | | |
| 16. | 4.17.Гаалийн хорио цээрийн хяналтын үйл ажиллагааг боловсронгуй болгох, цахимжуулах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 1.Алтанбулаг, Замын-Үүд, Боршоо боомтуудад халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг авахад шаардлагатай багаж, тоног төхөөрөмж, ариутгалын байгууламж, сэжигтэй зорчигчийг түр тусгаарлах өрөөгөөр хангасан.<br>2.ДЭМБ-ын ОУЭМД-ийн шаардлага хангасан чадавхын гэрчилгээтэй боомт байхгүй байна.<br>3.ГЕГ-ын даргын 2023 оны 62 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсэг Экспортын гэрчилгээ, дамжуулан өнгөрөх мэдэгдлийг | 1.Хилийн Бичигт, Гашуунсухайт, Шивээхүрэн боомтуудад халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг авахад шаардлагатай багаж, тоног төхөөрөмж, ариутгалын байгууламж, сэжигтэй зорчигчийг түр тусгаарлах өрөөгөөр хангагдсан байна.<br>2.ДЭМБ-ын ОУЭМД-ийн шаардлага хангасан чадавхын гэрчилгээ авах бэлтгэл ажлыг Чингис хаан" олон улсын нисэх буудал дахь гаалийн газар хангасан байна.<br>3.Экспортын гэрчилгээ, дамжуулан өнгөрөх мэдэгдлийг цахимаар олгох | 1. Хилийн Бичигт, Гашуунсухайт, Шивээхүрэн боомтууд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг авахад шаардлагатай багаж, тоног төхөөрөмж, ариутгалын байгууламж, сэжигтэй зорчигчийг түр тусгаарлах өрөөгөөр хангах судалгааг гаргасан.<br>Гашуунсухайт боомтын шалган нэвтрүүлэх цогцолбор 2024 онд шинээр ашиглалтад орсонтой холбогдуулан шаардлага хангасан сэжигтэй зорчигчийг түр тусгаарлах өрөөг ашиглалтад оруулсан.<br>"Хөгжлийн хөтөч" төслийн хүрээнд нүүрсний ачаа тээврийн 6 ширхэг, зорчигчийн чиглэлд 3 ширхэг нийт 9 халдваргүйжүүлэлтийн байгууламжийг ашиглалтад оруулж, халдваргүйжүүлэлтийг хийсэн.<br>Ачааны тээврийн хэрэгслийг халдваргүйжүүлэх зориулалтын байгууламжийг ашиглалтад оруулж, Шивээ хүрэн терминаль ХХК-тай түрээсийн гэрээгээр Хүслийн хийморь ХХК халдваргүйжүүлэлтийг хийлгэсэн.<br>Боомтын сэргэлтийн үндэсний хорооны ээлжит хуралд Бичигт боомтын ерөнхий төлөвлөгөө ноцтой байдлын үед боомтын бэлэн байдлыг хангах болон хорио цээрийн хяналт хийхэд зайлшгүй шаардлагатай барилга байгууламж, талбай, техник тоног төхөөрөмжийг үндэслэн төлөвлөх, байгаль орчны үнэлгээг хийлгэх саналыг дэвшүүлсэн.<br>Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд "Шивээ хүрэн-Сэхэ боомтын төсөл"-ийг хэрэгжүүлэгч "Нарийн сухайтын төмөр зам" ХХК-ийн бүтээн байгуулалтын ажлын зурагтай танилцаж, хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын асуудлаар саналуудыг хүргүүлсэн. | 2024.01.01<br>-<br>2024.11.30 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | цахимаар олгох судалгаа хийсэн. 4.ДЭМБ-ын Олон улсын эрүүл мэндийн дүрмийг хэрэгжүүлэх үндсэн чадавхын хөндлөнгийн хамтарсан үнэлгээний баг Монгол Улсад 2023 оны 11 дүгээр сарын 17-24 ний өдрүүдэд ажилласантай холбогдуулан 18 гаалийн газар, хороодоос судалгаа авч, 5 боомтод мэргэжлийн байгууллагатай хамтран газар дээр нь үнэлгээг хийж, үнэлгээний нэгдсэн дүнг Шадар сайдын түвшинд танилцуулж, 2024 онд хэрэгжүүлэх ажлын зөвлөмжийг гаргасан. 5.Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлж буй "Ургамал, малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдлыг | бэлтгэл ажлыг хангаж, нөхцөл боломжийг бүрдүүлсэн байна. 4.ДЭМБ-ын Олон улсын эрүүл мэндийн дүрэм (ОУЭМД-2005)-ийг хэрэгжүүлэх үндсэн чадавхын хөндлөнгийн хамтарсан үнэлгээний багаас Засгийн газарт хүргэгдсэн нэгдсэн зөвлөмжид тусгагдсаны дагуу 19 Газар, хороодын "Нийгмийн эрүүл мэндийн хариу арга хэмжээний төлөвлөгөө"-г Шадар сайдын 2023 оны 28 дугаар тушаалаар баталсан журмын үйл явдал бүрээр нарийвчлан боловсруулж, батлуулах 5.Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлж буй "Ургамал, малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдлыг сайжруулах нь" төслийн хүрээнд | ГЕГ-ын даргын 2024 оны 130 дугаар тушаалаар баталсан "Үнэлгээний хороо батлуулах тухай" ажлын хэсэгт ажиллан, хүний халуун хэмжигч төхөөрөмжийн техникийн тодорхойлолтыг боловсруулан, нээлттэй тендерийг шалгаруулж, нийлүүлэгч компанийг сонгон, худалдан авалт хийлгэн гаалийн Бичигт, Гашуун сухайт, Шивээ хүрэн зэрэг 7 газрыг 8 термокамер буюу зорчигчийн биеийн дулааныг хэмжигч төхөөрөмжөөр хангасан.<br>2.ДЭМБ-ын ОУЭМД-ийн шаардлага хангасан чадавхын гэрчилгээ авах бэлтгэл ажлыг ЧХОУНБГГ хангах зорилгоор ДЭМБ-ын Хөндлөнгийн үнэлгээний зөвлөх багийн зөвлөмжийн дагуу дараах бэлтгэл ажлуудыг гүйцэтгэсэн байна.<br>Гаалийн Ерөнхий газрын 2024 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн А/452 дугаар тушаалаар "Зорчигчийн эрүүл мэндийн мэдүүлэг"-ийг шинэчилж, нийт 2 сая төгрөгний санхүүжилтыг олгон 20000 ширхэг эрүүл мэндийн мэдүүлгийг хэвлүүлж, нөөцийн бэлэн байдлыг хангасан.<br>Хөрш зэргэлдээ болон бусад орнуудад дэгдсэн Улаанбурхан өвчний тохиолдол Монгол улсад нууц үедээ зөөвөрлөгдөж, батлагдсантай холбогдуулан БНКазакстан улсаас шууд нислэгээр ирсэн 30 агаарын хөлгийн 2658 зорчигчдод (монгол 1057 гадаад 1601) термокамераар эрүүл мэндийн тандалт хийж, хил нэвтрүүлсэн.<br>Хилийн нэвтрэх цэгт халдварт өвчний сэжигтэй тохиолдол илэрсэн үед халдвараас сэргийлэх хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах, халдвараас сэргийлэх хариу арга хэмжээг зөв, оновчтой, шуурхай хэрэгжүүлэх талаар ээлжийн ахлах, гаалийн улсын байцаагчдад мэдлэг олгох, чадамжийг дээшлүүлэх зорилгоор "Чингис хаан олон улсын нисэх буудлын "Хилийн нэвтрэх цэгт | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | сайжруулах нь" төслийн хүрээнд ГЕГ-ын даргын 2023 оны А/62 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсэг гаалийн хорио цээрийн үйл ажиллагааг цахимжуулах 16 модулийг боловсруулж, энэ хүрээнд одоогийн үйл ажиллагааны /AS-IS/ болон ирээдүйн үйл ажиллагааны системийн зорилтот /To-Be/ загварчлалыг бэлэн болгосон. | "Хилийн хяналт удирдлагын систем"-ийн хөгжүүлэлтийн хүрээнд www.gaali.mn цахим системээр дамжуулан гаалийн харилцаанд оролцогчдын өргөдөл, гомдол мэдээлэл хүлээн авах нэгдсэн сувгийг бий болгох, хорио цээрийн эрсдэл тооцох аргачлалыг програмчлах, гаалийн автоматжуулсан цахим системийн зарим модулийг гар утасны программд шилжүүлэн ашиглах апплейкшныг боловсруулж, нэвтрүүлнэ. | нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүсгэж болзошгүй үйл явдал" сэдэвт ширээний дасгал сургуулилтыг 2024 оны 11 дүгээр сарын 18-23-ны өдрүүдэд А, Б, В, Г ээлжийн 120 гаалийн улсын байцаагч, ариутгагчдыг хамруулан зохион байгуулсан.<br><br>Олон улсын аялал жуулчлал, зорчигчийн нэвтрэх хурд, бүртгэлийн цэгийн тоо нэмэгдүүлэх, үзлэгийн цэгийн талбайг өргөтгөх, зорчигчийн эрүүл мэнд болон гэрийн тэжээвэр амьтны үзлэгийн цэгийг нислэг үйлдвэрлэлтэй уялдуулан өөрчлөх ажлын хүрээнд 2024 оны 3 дугаар сард Чингис хаан ОУНБ-ын олон улсын явах бүртгэл, бизнес лонжийн хэсэгт байрлах 3 ширхэг цацрагийн хяналтын төхөөрөмжийн байрлалыг өөрчлөх ажлыг Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт компаниар гүйцэтгүүлсэн байна.<br>3. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй "Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл"-ийн хүрээнд Гаалийн ерөнхий газрын даргын А/115 дугаар тушаалаар ажлын хэсгийг шинэчлэн байгуулж, хорио цээрийн хяналтын чиглэлээр 16 модуль бүхий төлөвлөгөө боловсруулан экспортын гэрчилгээ, дамжуулан өнгөрөх мэдэгдлийг цахимаар олгох тусгайлсан модулыг бий болгосон. Гаалийн ерөнхий газар болон харьяа газар, хороодоос ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд нийт 2150 ширхэг экспортын гэрчилгээ олгосноос ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ 1686 ширхэг, БНХАУ-д хивэг экспортлох гэрчилгээ 164 ширхэг, гэрийн мод, модон материалд 212 БНХАУ-д буудайн гурил экспортлох гэрчилгээ 88 ширхэгийг тус тус олгосон. Ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бараанд дамжин өнгөрүүлэх мэдэгдэл 140 ширхэг, | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | импортын мэдэгдэл 2489 ширхэгийг Гаалийн ерөнхий газар, газар, хороодоос цахимаар олгоход ГЕГ-аас мэргэжлийн зөвлөгөө өгч ажилласан.<br>Гаалийн apqs.gaali.mn цахим системээр 1524 аж ахуйн нэгжээс ирүүлсэн албан хүсэлт хүлээн авснаас мал, амьтны гаралтай бараанд экспортын гэрчилгээг 2336 аж ахуйн нэгжид 5508 ширхэгийг олгож, БНХАУ-д 21515.8 тн адууны мах, 18585.6 тн дулааны аргаар чанаж боловсруулсан үхэр, хонь, ямааны мах, Иран, Ирак, Азербайджан, Узбекистан, Вьетнам улсад, 23149.4 тн хонь, ямааны мах, БНХАУ-д адууны шир 128957ш, үхрийн хагас боловсруулсан шир 108725 ш, ямааны боловсруулсан арьс 39762540ш, хонины угаасан ноос 7476.5тн, ноолуур 4775.7тн-ыг тус тус экспортлоход гаалийн хорио цээрийн хяналтыг хийсэн байна.<br>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон Хүнс, хөдөө аж ахуй Хөдөө аж ахуйн биржтэй хамтран төрийн болон төрийн бус байгууллагын экспортын нэг цонхны систем /Export.mofa.gov.mn/-д гаалийн хорио цээрийн системийн холболтын үйл ажиллагааг 2023 оны 07 дугаар сарын 01- ний өдрөөс эхлүүлэн гаалийн хорио цээрийн Caps.gaali.mn системийг холбож ГЕГ-ын Хорио цээрийн хэлтсээс олгож буй "Экспорт, импорт хорио цээрийн гэрчилгээ, мэдэгдлийн систем", "Экспортын нэг цонхны систем"-тэй уялдуулан шинэчлэгдэж, ААН-ийн экспортод зарцуулах цаг, хугацааг багассан.<br>Export.mofa.gov.mn цахим нэгдсэн системээр итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний хариу, тохирлын гэрчилгээ, гарал үүслийн гэрчилгээ, мал эмнэлгийн гэрчилгээг цахим хэлбэрээр олгож гаалийн мэдээллийн систем рүү дэмжуулан мах, махан бүтээгдэхүүний экспортын гэрчилгээг 2-4 цагт багтаан олгож | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ажиллаж, гадаад худалдаанд зарцуулагдах цаг хугацааг багасган, худалдааг хөнгөвчилж ажилласан.<br>Мал эмнэлгийн ерөнхий газарт. Амьтан, ургамал тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хууль"-д 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдөр нэмэлт өөрчлөлт орж, 2024 оны 02 дугаар сарын 13-ны өдрөөс Гаалийн байгууллагаас олгож буй экспортын гэрчилгээ, импортын болон дамжуулан тээвэрлэх мэдэгдэл олгох, баталгаажуулах чиг үүрэг ХХААХҮЯ, МЭЕГ-т шилжиж буйтай холбогдуулан 2024 оны 03 дугаар сарын 22-ны тус яамтай хамтарсан ажлын хэсэг байгуулагдаж, Хорио цээрийн хэлтсээс холбогдох баримт бичгийн жагсаалт, гэрчилгээ, мэдэгдлийн загварыг дээрх байгууллагуудад хүргүүлж, бусад шаардлагатай мэдээллийг өгч ажилласан. 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын А/534 тоот "Ажлын хэсэг байгуулах тухай" тушаал гарч 2024 оны 12 дугаар сард багтаан чиг үүргийг шилжүүлэн, авах мэдээ, мэдээлэл харилцан солилцох ажлууд хийгдсэн.<br>4. ДЭМБ-ын Олон улсын эрүүл мэндийн дүрэм (ОУЭМД-2005)-ийг хэрэгжүүлэх үндсэн чадавхын хөндлөнгийн хамтарсан үнэлгээний багаас гаргасан 5 зөвлөмжийн 1 болох Бэлэн байдлын төлөвлөгөөнд Шадар сайдын 2023 оны 28 дугаар тушаалын үйл явдал (хүний олон улсын хөл хориот болон малын гоц халдварт өвчин, ургамлын хорио цээр, хүнсний аюулгүй байдлын өөрчлөлт, хими, цацрагийн осол, хордлого) тус бүрээр тодотгол хийх ажлын хүрээнд 2024 оны 03 сарын 12-ны өдөр цахим хуралдаанаар, 2024 оны 06 дугаар сарын 14-ний 02-1.2/2450 дугаар, 2024 оны 08 дугаар сарын 05-ны | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | өдрийн 02/3100 дугаар албан бичгээр тус тус холбогдох чиглэлийг өгсөн.<br>Эрүүл мэндийн сайдын 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/85 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсгээс гаргасан “Нэг эрүүл мэнд” зарчимд тулгуурлан бэхжүүлэх зорилго бүхий Эрүүл мэндийн аюулгүй байдлын төлөвлөгөөний үндсэн агуулгатай харьяа гаалийн газар, хороодын Бэлэн байдлын төлөвлөгөөг уялдуулсан бөгөөд 2024 оны 11 сарын 30-ны байдлаар 19 гаалийн газар, хороо Бэлэн байдлын төлөвлөгөөгөө шинэчилж, баталгаажуулсан байна.<br>5.Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр “Интерактив” ХХК-тай хамтран хэрэгжүүлж буй “Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах” төслийн хүрээнд гаалийн хорио цээрийн хяналт шалгалтын үйл ажиллагааг цахимжуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдөр ГЕГ-ын даргын А/115 тушаалаар шинэчлэн батлуулсан.<br>Ажлын хэсэг 16 модулийн хүрээнд төлөвлөгөө гарган Хорио цээрийн эрсдэлийг, гаалийн эрсдэлийн удирдлагын модультай уялдуулах зорилгоор эрсдэлийн нэгдсэн журамд дурдсан эрсдэл тооцох өгөгдлүүдийг цахимжуулах,<br>-Төрийн байгууллагуудтай өгөгдөл солилцох,<br>-Лабораторийн модулийн шаардлагын тодорхойлолт,<br>-Гар утасны апплейкшнийн загвар,<br>-Хорио цээрийн модулийн цацраг, шарил, зорчигч, тээвэр,<br>-Халдваргүйжүүлэлтийн дэд модульд засвар, сайжруулалт,<br>-Хорио цээрийн хяналтын явцад буцаах мэдэгдлийн модуль,<br>-Зорчигчийн эрүүл мэндийн мэдүүлэг хуудаст нэмэлт, өөрчлөлт оруулах модуль, | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | -Халдваргүйжүүлэлт, шарилын бүртгэл, түр тусгаарлалтын модуль,<br>-Зорчигч, тээврийн хэрэгслийн эрүүл мэндийн хяналтыг захиргааны статистикийн бүртгэлийн мэдээнд оруулах модулийг тус тус боловсруулан хөгжүүлж, Гаалийн автоматжуулсан мэдээллийн систем /CAIS/-д холбоход бэлэн болгосон.<br>Уг төсөл 2025 оны 04 дүгээр сарын 30 хүртэл үргэлжилэхээр төлөвлөгдсөн байна. | | |
| 17. | 4.20.IRU олон улсын байгууллага болон Монголын авто тээвэрчдын нэгдсэн холбоо (НАРТАМ) –той хамтран TIR-EPD, e-TIR системүүдтэй мэдээллийг цахимаар солилцох | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | -ОУАТХ-ны программ хангамжийн багтай цахимаар холбогдож 2 талын хугацаа нь дууссан эрхийг нээж мэдээллээ солилцож эхлэхээр тохиролцсон.<br>-Гаалийн автоматжуулсан мэдээллийн CAIS системд TIR-EPD мэдээллийг хүлээн авах, боловсруулах программыг хөгжүүлэлтийг хийж, тест хийж ажилласан. | ОУАТХ-ны программ хангамжийн багтай цахимаар холбогдож 2 талын хугацаа нь дууссан эрхийг нээлгэнэ. | Олон Улсын автотээврийн холбооны програм хангамжийн багтай Монгол Улсын гаалийн байгууллагын CAIS системд ТИР-ын гаалийн урьдчилсан цахим мэдүүлгийн систем (TIR-EPD)-ийг уялдуулж, холбох ажлыг 2021 оны 9 дүгээр сараас эхлэн хэрэгжүүлсэн. ОУАТХ-ны программ хангамжийн багтай цахимаар холбогдож 2 талын хугацаа нь дууссан эрхийг нээлгэж, IRU-ийн зөвлөх Вахтанг Зарандиятай 2024.05.22-ны өдөр харилцан санал солилцож, тохиролцсоны дагуу 2024.10.24-ний өдрөөс эхлэн IRU-тай TIR-EPD-ийн 6 элементийг туршиж, дараа нь CAIS-т нарийн үйлдлүүдийг хийсэн.ГЕГ-ын дэргэдэх МТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Ганзоригоор ахлуулсан ажлын хэсэг 2024.11.10-2024.11.15-ны өдрүүдэд Алтанбулаг, Замын-Үүд боомтод томилолтоор ажиллаж CAIS-т ТИР-ын гаалийн урьдчилсан цахим мэдүүлгийн систем (TIR-EPD)-ийг холбох туршилтыг хийж, амжилттай нэвтрүүлсэн. Дээрх ажилтай холбоотойгоор МТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Ганзориг 2024.11.11-ний өдөр CAIS-т TIR-ын урьдчилсан цахим мэдүүлгийн систем TIR-EPD-ийг бүртгэх сургалтыг ЗҮГГ-т зохион байгуулж, ЗҮГГ-ын 15 албан хаагчийг танхимаар, УБГГ, СЭГГ, БӨГГ, ХОГГ, ДАГГ-ын 98 албан хаагчийг цахимаар оролцуулсан. | 2024.01.01<br>-<br>2024.11.30 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Мөн ГЕГ-ын дэргэдэх МТГ-аас нийт ГУБ нарт зориулан "ТИР карней бүхий бараа тээврийн хэрэгслийг CAIS системд бүртгэх, хяналт тавих гарын авлага" боловсруулан CERP-д байршуулсан. Олон улсын автотээврийн холбооны ТИР болон дамжин өнгөрөх тээврийн хэлтсийн ахлах зөвлөх Вахтанг Зарандия нь 2024.11.18-ны өдөр ГЕГ-ын удирдлгуудтай уулзаж, CAIS системд ТИР-ын гаалийн урьдчилсан цахим мэдүүлгийн систем (TIR-EPD)-ийг холбож, нэвтрүүлсэн ажлын явцыг дүгнэсэн. ГЕГ-ын даргын 2024.11.19-ний өдөр баталсан удирдамжийн дагуу ХБГ, ОНХА-ын албан хаагч нар Замын-Үүд боомтод 2024.11.20-ны өдрөөс 23-ны өдрүүдэд ажиллаж Олон улсын автотээврийн холбооны ТИР болон дамжин өнгөрөх тээврийн хэлтсийн ахлах зөвлөх Вахтанг Зарандия, МАТНХ-ны гүйцэтгэх захирал Д.Наранпүрэв нарт Замын-Үүд боомтын ачааны терминалд ТИР, транзит тээвэрлэлтийг нэвтрүүлэх замын эгнээ, гаалийн байгууллагын бүртгэл, хяналтыг танилцуулж, ТИР-ын самбарыг байршуулахтай холбоотой асуудлаар санал солилцсон. Цаашид Замын-Үүдээс бусад боомтоор ТИР карней бүхий бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлсэн мэдээг CAIS-т хүлээн авах хугацааг тодруулах, ойлголтын зөрүүг арилгах зорилгоор ГЕГ-ын ХБГ, ГЕГ-ын дэргэдэх МТГ-ын албан хаагч нар IRU-ын програм хангамжийн багийнхантай хамтарч ажиллаж байна.<br>Үүний үр дүнд: 1. Монгол Улсын гаалийн байгууллагын CAIS системд 2024.11.24-ний өдөр ТИР-ын гаалийн урьдчилсан цахим мэдүүлгийн систем (TIR-EPD)-ийг холбож, нэвтрүүлсэн.<br>2. CAIS-т TIR-ын урьдчилсан цахим мэдүүлгийн систем TIR-EPD-ийг бүртгэх сургалтыг 2024.11.11-ний өдөр ГЕГ-ын | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дэргэдэх МТГ-ын албан хаагч нартай хамтран ЗҮГГ-т зохион байгуулж, ЗҮГГ-ын 15 албан хаагчийг танхимаар, УБГГ, СЭГГ, БӨГГ, ХОГГ, ДАГГ-ын 98 албан хаагчийг цахимаар оролцуулсан.<br>3. IRU-ийн ТИР болон транзит хариуцсан ахлах зөвлөх Вахтанг Зарандиятай хамтран TIR-EPD холболтын гүйцэтгэлийн үнэлгээ, CAIS дахь ТИР карней статусыг шалгах, EGIS шалгалтыг хэрхэн хийсэн тухай, EPD028/EPD016 мессежийг автоматжуулахтай холбоотой техникийн асуудлуудыг хамтран хянасан.<br>4. БНХАУ-ын ГЕГ-ын ХШГ-ын дарга Жанг Тао-д 2024.12.02-ны өдрийн 02-1/4999 дугаартай албан бичгээр Монгол Улсын гаалийн байгууллагын CAIS системд ТИР-ын гаалийн урьдчилсан цахим мэдүүлгийн систем (TIR-EPD)-ийг холбож, нэвтрүүлсэн тухай мэдээллийг хүргүүлсэн.<br>5. Замын-Үүдээс бусад боомтоор ТИР карней бүхий бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлсэн мэдээг CAIS-т хүлээн авах хугацааг тодруулах, ойлголтын зөрүүг арилгах зорилгоор ГЕГ-ын ХБГ, ГЕГ-ын дэргэдэх МТГ-ын албан хаагч нарыг IRU-ын програм хангамжийн багийнхантай уулзаж, хамтарч ажиллах боломжийг цаг алдалгүй зохион байгуулахтай холбоотой саналаа 2024.12.02 өдөр албан бичгээр хүргүүлэх ажлыг зохион байгуулсан байна. | | |
| 18. | 4.21.Тээврийн хэрэгсэл эзэмшигч нар хилийн боомтоор нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээллийг гар утаснаасаа гаалийн байгууллагын CAIS системд илгээх, мобайл аппликейшн шинээр хийлгэх | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Тээврийн хэрэгсэл эзэмшигч нар хилийн боомтоор нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээллийг CEPS-д нөхөж бичээд, | 1.Тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээллийг гар утаснаасаа гаалийн байгууллагын CAIS системд | Улсын хилээр түр хугацаанд нэвтэрч байгаа тээврийн хэрэгсэл хил нэвтрэх хүсэлтийг ceps.gaali.mn вэб сайтаар хандаж илгээж байна. Тус бүртгэлийг илгээх тээврийн хэрэгслийн жолооч, тээвэрлэгч байгууллага нь хил дээр зөөврийн компьютер байнга ашиглах хүндрэлтэй нөхцөл байдал үүсэх, гар утаснаас холбогдсон тохиолдолд тээврийн хэрэгслийн | 2024.01.01 - 2024.11.30 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | гаалийн байгууллагын CAIS-т илгээж бүртгүүлж байна. | илгээх, мобайл аппликейшн шинээр хийлгэх бодлогын даалгавар боловсруулж, Мэдээллийн технологийн төвд хүргүүлнэ.<br>2.Мобайл аппликейшн туршилтаар ашигласан байна.. | улсын бүртгэлийн серийн дугаарын үсгийг латин болон крилл үсэг холих зэрэг шалтгаанаар бүртгэлийг алдаатай илгээж хил нэвтрэлтийг удаашруулах, улмаар гаалийн байгууллага дээрх бүртгэлийг хийх зэрэг нөхцөл байдал үүсээд байна.<br>Иймд улсын хилээр түр хугацаанд нэвтэрч байгаа гадаад, дотоодын тээврийн хэрэгслийн улсын хилээр нэвтрэх бүртгэлийн хүсэлтийг гаалийн байгууллагад илгээх гар утсанд зориулсан програм хангамжийн хөгжүүлэлт хийлгэх шийдлийг судалж, СМТТ УТҮГ-т саналаа 2024.09.24-ний өдрийн 02-1/3895 дугаартай албан бичгээр хүргүүлж, хамтран ажилласан.<br>Дээрх асуудлыг ГЕГ-ын дэргэдэх МТГ-т шийдвэрлэх боломжгүй тул И-Монгол Академи УТҮГ-ын систем нэгтгэлийн газрын төслийн менежер С.Цэвээнсүрэн, системийн шинжээч А.Эрдэнэцэцэг, цахим засаглалын хэлтсийн процесс аналист Г. Будням, шинжээч Г.Оюунгэрэл нартай уулзалт зохион байгуулж, Е-Монголиа арр-д улсын хилээр нэвтрүүлэх тээврийн хэрэгслийг бүртгүүлэх хүсэлтийг хүлээн авч, гаалийн байгууллагатай холбогдох модул гаргуулахаар тохиролцсон.<br>Үүний дагуу тээвэрлэгчээс хил нэвтрүүлэх тээврийн хэрэгслийн бүртгэлийн хүсэлт илгээх асуудлыг гар утасны програм хангамжид суурилсан хэлбэрээр цахим төлбөрийн баримтын ebarimt системээс шийдвэрлэх технологийн гарц, шийдлийг судалж, И Монгол Академи УТҮГ-т захиалагчийн шаардлага, процессын зураглалыг тайлбарын хамт хүргүүлэн хамтран ажиллаж байна.<br>Үр дүн:<br>1. Цаашид боомтын орох, гарах хаалганы эгнээ замууд дээр бүртгэлтэй холбоотой асуудлаар бөөгнөрөл үүсгэхгүйн тулд тээврийн хэрэгслийн жолооч нар гар | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | утаснаасаа бүртгүүлэх хүсэлтээ илгээх боломжийг бүрдүүлэхээр гар утасны апп шинээр хийлгэхийн тулд үнийн дүнгээс шалтгаалаад цахим хуудсаар дамжуулан тендер зарлах гэх мэтээр улсын төсвөөс тодорхой хэмжээний зардал гарах тооцоолол судалгаа хийсэн.<br>2. И-Монгол Академи УТҮГ-ын шинжээч нартай хамтарсан уулзалтуудыг зохион байгуулж, захиалагчийн шаардлага, процессын зураглалыг тайлбарын хамт хүргүүлсэн.<br>3. Апп-р тээврийн хэрэгслийг бүртгүүлэхэд:<br>-Иргэн регистрийн дугаараар хүсэлтээ илгээхэд 5 минут<br>-Хур системээс мэдээлэл харуулахад 1 мин буюу нийт 6 минут зарцуулдаг болно.<br>4. Дээрх програмыг улсын төсвөөс зардал гаргахгүйгээр төлбөргүй хийлгэж 2024.12.20-ны өдрөөс туршилтаар нэвтрүүлэхээр ажиллаж байна. | | |
| 19. | 4.22.Автозамын хилийн боомтод суурилуулсан ухаалаг гарцын тоног төхөөрөмжийг ашиглан хил хамгаалах байгууллагатай хамтран ажиллаж, хилээр нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийг нэгтгэнэ | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Замын-Үүд, Гашуунсухайт, Шивээхүрэн боомтын бүтээн байгуулалттай уялдуулан ухаалаг гарцын тоног төхөөрөмжөөр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг бүртгэж эхэлсэн. Хил хамгаалах ерөнхий газартай хамтарсан ажлын хэсэг байгуулахаар ажиллаж байна | 1.Хил хамгаалах ерөнхий газартай хамтарсан ажлын хэсэг байгуулж, солилцох мэдээллийг тохирсон байна.<br>2.Ухаалаг гарцын тоног төхөөрөмжийг ашиглан хил хамгаалах байгууллагатай хилээр нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийг ижилсгэсэн байна. | Хилээр нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийн зөрүү гаргахгүй, мөн хилийн хяналтын байгууллагуудын давхардсан шалгалтыг багасгаж, хяналтаа сайжруулахын тулд автозамын хилийн боомтууд дээр гаалийн байгууллага болон хил хамгаалах байгууллагын тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналтын системийг уялдуулахаар хамтран ажиллаж байна. Дээрх ажлыг хэрэгжүүлэхээр ХХЕГ-ын Холбоо, мэдээллийн технологийн аюулгүй байдлын газартай хамтарсан ажлын хэсэг байгуулагдаж, гаалийн байгууллагаас:<br>1. Тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээллийг өгөгдөл дамжуулах байдлаар илгээж, танай байгууллагаас тухайн тээврийн хэрэгслийн жолооч, зорчигч нарын тодорхой мэдээллийг хүлээн авах; | 2024.01.01 - 2024.11.30 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2. Хилээр түр хугацаагаар тээврийн хэрэгсэл оруулсан гадаадын иргэн, харьяалалгүй хүн хилээр гарах үед нь түр хугацаагаар оруулсан тээврийн хэрэгслийн бүртгэлийг шалгаж, нягтлах зэрэг ажлуудыг хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөж ажилласан. Үүний үр дүнд улсын хилээр орох болон гарах талд хил нэвтэрсэн авто тээврийн хэрэгслийн дугаараар ХХЕГ-аас сервисээр мэдээлэл татах боломжийг бүрдүүлсэн. Тус мэдээлэлд жолооч, зорчигчийн овог, нэр, регистрийн дугаар, гадаад паспортын дугаар, төрсөн он сар өдрөөр Хил хамгаалах ерөнхий газрын баталгаажуулсан мэдээллийг хүлээн авч гаалийн хяналт шалгалтад ашиглах, эрсдэл тооцох боломжтой болгосон. Мөн цаашид төмөр зам, агаарын тээврийн хэрэгслээр хил нэвтэрсэн зорчигчийн мэдээллийг Хил хамгаалах байгууллагын баталгаажуулсан мэдээллийг авахаар ажиллаж байна.<br>Үр дүн:<br>1. ХХЕГ-ын Холбоо, мэдээллийн технологийн аюулгүй байдлын газартай хамтарсан ажлын хэсэг байгуулан ажиллаж, хамтарсан уулзалт зохион байгуулан, сервисын мэдээллээ дахин шинэчилж хүргүүлсэн.<br>2. Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх ХУН төслийн хүрээнд программ хийлгэж, автозамын хилийн боомтоор нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээлэл солилцох туршилтыг 2024 оны 11 дүгээр сард Замын-Үүд боомтод хийж, нэвтрүүлсэн болно. | | |

Хоёр. Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| УИХ, ЗАСГИЙН ГАЗАР, ЯАМ БОЛОН БУСАД АГЕНТЛАГААС БАЙГУУЛАГДСАН АЖЛЫН ХЭСЭГ | | | | | | | |
| 1 | Ажлын хэсгийн гишүүнээр ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | Монгол улсын Ерөнхий Сайдын 2024.11.18-ны өдрийн 123 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт ажилласан байна. | "Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрийн гол төсөл, хамтын ажиллагааны зорилтуудын жагсаалтын шинэчилсэн хувилбарын хэрэгжилтийг гаргаж 2024.12.18-ны өдрийн 02/5270 дугаартай албан бичгийн хавсралтаар ЭЗХЯ-нд хүргүүлж ажиллав. 3-р сарын 21-ний өдөр ЭЗХЯ гадаад худалдааны цахим 1 цонхны талаарх хэлэлцүүлэгт оролцож үзэл бодол байр сууриа илэрхийлсэн. Дээрх хөтөлбөрийн Худалдааг дэмжих, Эрүүл мэндийн салбар дахь хамтын ажиллагааны хүрээнд гаалийн байгууллагын хариуцах 14, 15, 16, 17, 33 дугаар арга хэмжээний талаарх мэдээллийг бэлтгэн ЭЗХЯ-д 2024.12.18-ны өдрийн 02/5270 дугаартай албан бичгийн хавсралтаар хүргүүлсэн. | 2024.01.01 2024.11.30 | 100 |
| 2 | Ажлын хэсгийн гишүүнээр ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | Монгол улсын Ерөнхий Сайдын 2024.10.07-ны өдрийн 72 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт ажилласан байна. | "НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн 2004 оны 1540-р тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор стратегийн ач холбогдол бүхий зарим аюултай бараа бүтээгдэхүүнд тавих хяналтыг сайжруулах эрх зүйн орчныг бий болгох хуулийн төслийг боловсруулж танилцуулах ажлын хэсгийн хуралд тухай бүр орж, гаалийн байгууллагын зүгээс шаардагдах мэдээ мэдээлэлээр хангаж ажилласан. НҮБ-ын АЗ 1540 тогтоолын хүрээнд стратегийн худалдааны хяналтын хууль, эрх зүйн орчныг бий болгох хэрэгцээ, шаардлага, ач холбогдлын талаар мэдээлэл өгөх уулзалтад 1-р сарын 15-ны өдөр оролцож үзэл бодол байр сууриа илэрхийлсэн. Европын холбооны "P2P" хөтөлбөрийн зохицуулагч ХБНГУ-ын Эдийн | 2024.01.01 2024.11.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | засаг, экспортын хяналтын албатай хамтарсан "Зэвсгийн экспортын үр дүнтэй хяналтыг дэмжих төсөл"-ийн хүрээнд Кавказ болон Төв Азийн бүс нутгийн орнуудад зориулсан семинарт 2024 оны 11 дүгээр сарын 06-наас 07-ны өдрүүдэд оролцсон. | | |
| 3 | Ажлын хэсгийн гишүүнээр ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | Хүнсний хангамж аюулгүй байдлын асуудлаар уулзалт, нэвтрүүлэгт оролцон гаалийн байгууллагын байр суурийг илэрхийлэх | МҮОНРТ-д 1-р сарын 10-ны өдөр "Хүнсний хувьсгал" ЗГ-ын 36 тогтоолын хэрэгжилт, 2-р сарын 27-ны өдөр Хүнсний хувьсгал ба Хүнсний аюулгүй байдлын хяналт сэдвээр оролцож тус тус үзэл бодол байр сууриа илэрхийлсэн. 1-р сарын 17-ны өдөр Махны экспортыг нэмэгдүүлэх нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангах үүрэг бүхий ажлын хэсгийн уулзалтад оролцсон. 1-р сарын 31-ний өдөр Төрийн ордонд зохион байгуулагдсан хүнсний аюулгүй байдлын талаарх хэлэлцүүлэгт оролцов. 2-р сарын 21-ний өдөр УИХ-ын тамгын газар, хүнсний аюулгүй байдлын чиглэлээр зохион байгуулсан уулзалтад мэдээлэл хийж оролцов. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газарт Монгол Улсын Их Хурлын 2022 оны "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" 36 дугаар тогтоолын хэрэгжилт, явцын тайлан, тулгамдаж буй асуудлын талаарх танилцуулга, мэдээлэл, хийх ажлын төлөвлөгөө гаргаж улирал тутам 02/509, 02/700 дугаартай албан бичгээр хүргүүлж ажилласан. Дээрх тогтоолын хэрэгжилт явцын талаар Ерөнхийлөгчийн үйлдвэр үйлчилгээний бодлогын зөвлөх Ч.Даваабаяр, Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хүнсний төсөл хөтөлбөрийн албаны дарга В.Мөнгөнсүх,Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн референт Б.Сайнбуян, Д.Цогт УИХ-ын гишүүний Мандхайн зөвлөх нартай уулзалтыг 10-р сарын 04-ны өдөр уулзалт зохион байгуулав. 10-р сарын 22-ны өдөр Хүнсний аюулгүй байдал пестицидийн асуудлаар зохион байгуулсан семинарт оролцов.Төрийн ордонд 11-р сарын 28-ны өдөр зохион байгуулагдсан УИХ-ын 2022 оны "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар зарим авах арга хэмжээний тухай" 36 | 2024.01.01<br>2024.11.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тогтоолын хэрэгжилт явцын талаарх 4 дэх хэлэлцүүлэгт илтгэл тавьж танилцуулав. | | |
| 4 | Зөвлөлийн гишүүнээр ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | ЗТХ-ийн сайдын 2021.02.26-ны өдрийн А/24 дүгээр тушаалаар байгуулагдсан "Агаарын тээврийг хялбаршуулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зөвлөл"-ийн ажлын хэсэгт гишүүнээр ажилласан байна. | Агаарын тээврийг хялбаршуулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсгийн гишүүнээр ажиллаж, хөтөлбөрийн гаалийн байгууллагын чиг үүрэгт хамаарах арга хэмжээ, төлөвлөгөөний биелэлтийг хагас жил, жилийн эцсийн байдлаар ИНЕГ-т албан бичгээр хүргүүлж ажилласан. ИНЕГ-аас 2024.12.02-ны өдрийн 01/2745 бичгээр ирүүлсэн "Агаарын тээврийн хялбаршуулах зөвлөлийн 2025 оны төлөвлөгөө"-д тусгуулах санал боловсруулж, 2024.12.13-ны өдөр 02-1/5204 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. | 2024.01.01 2024.11.30 | 100 |
| 5 | Зөвлөлийн гишүүнээр ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөлийн ажлын хэсэгт ажиллах | ЗТЯ дээр 2-р сарын 2-ний өдөр зохион байгуулагдсан "Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөлийн ажлын хэсгийн хуралд оролцож байр сууриа илэрхийлэн, мэдээллээр хангаж ажиллав. ИНЕГ-аас 2024.07.05-ны өдрийн 01/1506 дугаартай албан бичгийн хавсралтаар ирүүлсэн "Монгол улсын агаарын хилийн орох цэгээр орсон гадаадын болон монгол улсад бүртгэлтэй агаарын хөлөг олон улсын хилийн боомтоор тогтоогдоогүй нисэх буудалд аргагүйдсэн буулт үйлдсэн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний нэгдсэн журам"-д нэмэлт өөрчлөлт оруулах төсөлтэй танилцаж, саналаа 2024.07.30-ны өдрийн 02-/3067 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. ИНЕГ-аас 2024.12.02-ны өдрийн 01/2749 бичгээр ирүүлсэн "Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөлийн 2025 оны төлөвлөгөө"-д тусгуулах саналыг 2024.12.06-ны өдрийн 02-1/5101 дугаартай албан бичгээр хүргүүлсэн болно. | 2024.01.01 2024.11.30 | 100 |
| 6 | Ажлын хэсгийн гишүүнээр ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | Монгол Улсын ЗГХЭГ-ын даргын 2023.10.30-ны өдрийн 97 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажилласан байна.<br><br>Франц-Монголын Ураны гэрээ /Татвар санхүү/ -нд | ЗГ-ын хуралдаанд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх Татвар, санхүүгийн асуудал хариуцсан ажлын дэд хэсэгт орж ажилласан. Ажиллах хугацаанд ажлын хэсгээс МУ-ын сайд, ЗГХЭГ-ын даргад хүргүүлэх Монгол, Францын хамтарсан "Бадрах энержи" ХХК-ийн хөрөнгө оруулагч Орано майнинг компаниас ирүүлсэн Хөрөнгө оруулалтын гэрээний төслийн асуудлаар хүргүүлэх санал, дүгнэлт, ажлын тайлантай танилцсан. Монгол, Францын хамтарсан Бадрах энержи ХХК-ийн хөрөнгө оруулагч Орано | 2024.01.01 2024.11.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хяналт тавих ажлын хэсэгт ажилласан байна. | Майнинг компаниас ирүүлсэн "Хөрөнгө оруулалтын гэрээ"-ний төслийг Монгол Улсын үндсэн хууль, олон улсын гэрээ, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд судалж санал, дүгнэлт боловсруулах, хөрөнгө оруулагч талтай хэлэлцээ хийх, төслийг тохирох эцэслэсэн хувилбарыг ЗГ-ын хуралдаанд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх Татвар, санхүүгийн асуудал хариуцсан ажлын дэд хэсгийн 2024.09.13-ны өдрийн хуралд оролцож МУ-ын ЗГ,Орано, "Бадрах энержи" ХХК-ийн хөрөнгө оруулалтын гэрээний шинэ хувилбартай танилцаж, саналаа viber-аар хүргүүлсэн. 2-р сарын 27-ны өдөр , 3-р сарын 5-ны өдөр Сангийн яам дээр "Ураны гэрээ"-ний асуудлаар тус тус зохион байгуулсан хуралд оролцож үзэл бодол байр сууриа илэрхийлж ажилласан. ЗГ-ын 2024.12.04-ний өдрийн хуралдааны шийдвэрийн дагуу ЗГХЭГ-ын даргын 2024.09.10-ны өдрийн 93 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн хүрээнд Бадрах энержи ХХК, Орано майнинг -ын Хөрөнгө оруулалтын гэрээний төслийг эцэслэх ажлын хэсгийн вакум хуралд 2024.12.04,05-ны өдрүүдэд оролцсон. ХОГ-ний төсөлд хүргүүлэх санал боловсруулж, 2024.12.09-ний өдрийн 02/5125 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. ЗГХЭГ-ын даргын 2024.12.20-ны өдрийн 140 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн хүрээнд Бадрах энержи ХХК, Орано майнинг-ын Хөрөнгө оруулалтын гэрээний төслийг Францын талтай хэлэлцэж, тохирох ажлын хэсгийн вакум хуралд 2024.12.21-ний өдөр оролцсон. ХОГ-ний төсөлд хүргүүлэх саналыг 2024.12.20-ны өдрийн 02/5311 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. | | |
| 7 | Ажлын хэсгийн гишүүнээр ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | Алтанбулаг, Замын-Үүд боомтод барилгын дотоод заслын материалыг хянах чиглэлээр бэхжүүлэх ажлын хэсэгт ажиллах | Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны 117 дугаар "Ажлын хэсэг байгуулах тухай" тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулагдсан "Дотоод орчны бохирдол ба бохирдуулагчаас урьдчилан сэргийлэхэд салбар хоорондын уялдааг сайжруулах тухай" хэлэлцүүлгэд сүүлийн 3 жилд импортолсон барилгын материалын статистик мэдээллийг | 2024.01.01<br>2024.11.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | нэвтрүүлсэн хилийн боомт болон тоо хэмжээ, үнийн дүнгээр гарган танилцуулга бэлтгэн оролцож, импортын барилгын материалын эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, шинжилгээний асуудлаар цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэдээлэл хийж, санал солилцсон. | | |
| 8 | Зөвлөлийн гишүүнээр ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | ГТСМТТ-ын удирдах зөвлөлийн ажлын хэсэгт ажиллах | ГТСМТТ-ын удирдах зөвлөлийн ажлын хэсэгт орж гаалийн байгууллагын мэдээллийн системийн талаарх мэдээллээр хангаж ажиллав. | 2024.01.01 2024.11.30 | 100 |
| 9 | Зөвлөлийн гишүүнээр ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | Зөвлөлийн гишүүнээр ажилласан байна. | Сангийн яамны дэргэдэх хөгжлийн бэршээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр гаалийн байгууллагын системд авч хэрэгжүүлсэн ажлын талаар мэдээлэл танилцуулга бэлтгэн дэд зөвлөлийн гишүүнээр ажилласан. | 2024.01.01 2024.11.30 | 100 |
| 10 | Төслийн удирдах хороонд ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | Хөгжлийн хөтөч дэд бүтэц төслийн удирдах хороонд ажиллах | Гаалийн байгууллагын Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжийн санхүүжилтээр хэрэгжиж буй төслийн хүрээнд Замын-Үүд хилийн боомтын бүтээн байгуулалтыг хийж гүйцэтгэн, хяналт тавьж ажилласан болно. | 2024.01.01 2024.11.30 | 100 |
| 11 | төслийн удирдах хороонд ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | Гадаад харилцааны Сайдын 2024 оны А/81 дүгээр тушаалаар байгуулагдсан “Олон улсын худалдааг дэмжих төсөл”-ийн удирдах хорооны ажлын хэсэгт ажилласан байна. | 12-р сарын 16-ны өдөр Гадаад харилцааны Сайдын зөвлөлийн хуралдаанаар “Монгол улсад гадаад худалдааг хөгжүүлэх төслийн хэрэгжилтийн асуудлаар удирдах хорооны“ хэлэлцсэн хуралд оролцож үзэл бодол байр сууриа илэрхийлсэн. | 2024.01.01 2024.11.30 | 100 |
| 12 | Эрүүл Монгол хүн төсөл, хөтөлбөр | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | Эрүүл Монгол хүн төсөл, хөтөлбөр хариуцсан албаны даргатай уулзаж, чөлөөт бүсийн үйл ажиллагааг танилцуулах | Эрүүл Монгол хүн төсөл, хөтөлбөр хариуцсан албаны дарга О.Чимэдсүрэнтэй 2024.01.25-ны өдрийн 11:00 цагт уулзаж, Алтанбулаг чөлөөт бүсэд 2020-2022 онд гаалийн болон бусад татваргүйгээр оруулсан согтууруулах ундааны талаар | 2024.01.01 2024.11.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | мэдээлэл өгч, гаалийн байгууллагаас хэрэгжүүлж байгаа арга хэмжээг танилцуулсан. | | |
| 13 | Биелэлт гаргаж, хүргүүлэх | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | ЭЗХЯ-д "Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Хятадын Засгийн газар хоорондын комиссын XVII хуралдааны мөрөөр хэрэгжүүлэх ажлын гаалийн байгууллагын чиг үүрэгт хамаарах ажлын биелэлт" хүргүүлэх. | ЭЗХЯ-ны ТНБД-аас ирүүлсэн 2024.01.02-ны өдрийн 03/01 дугаартай албан бичгийн дагуу "Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Хятадын Засгийн газар хоорондын комиссын XVII хуралдааны мөрөөр хэрэгжүүлэх ажлын гаалийн байгууллагын чиг үүрэгт хамаарах ажлын биелэлт"-ийн хүрээнд гаалийн байгууллагаас хэрэгжүүлсэн ажлын биелэлтийг 2023 оны 4 дүгээр улирлын байдлаар гаргаж, 2024.01.05-ны өдрийн 01/47 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. | 2024.01.01<br>2024.11.30 | 100 |
| 14 | Хэлэлцүүлэгт оролцох | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | ЗТХЯ-аас зохион байгуулах хэлэлцүүлэгт оролцох | ЗТХЯ-ны захиалгаар ДБ-ны санхүүжилтээр хийгдэж буй Монгол Улсад олон улсын худалдаа, тээвэр логистикийг бэхжүүлэх хувийн хэвшлийн оролцоо, Замын-Үүдэд хуурай боомт байгуулах техник, эдийн засгийн үнэлгээ хийх урьдчилсан судалгаа"-ны эцсийн тайлангийн хэлэлцүүлэгт 2024.07.03-ны өдөр оролцож саналаа илэрхийлж ажилласан. | 2024.01.01<br>2024.11.30 | 100 |
| 15 | Уулзалтад оролцох | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | ЭЗХЯ-ны Нийгмийн хөгжлийн бодлогын хэлтсээс зохион байгуулсан уулзалтад оролцох | ЭЗХ-ийн сайдын 2022.12.28-ны өдрийн А/167 дугаар тушаалаар баталсан "Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал"-ын дагуу ЭЗХЯ-ны Нийгмийн хөгжлийн бодлогын хэлтсээс 2024.01.30-ны өдрийн 11:00 цагт зохион байгуулсан "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө"-ний төслийг хэлэлцэх хуралд оролцож саналаа илэрхийлсэн. | 2024.01.01<br>2024.11.30 | 100 |
| **2024 ОНД БАТЛАГДСАН БУСАД АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ** | | | | | | | |
| 1 | Биелэлтэд хяналт тавьж ажиллах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | "Худалдааг хөнгөвчлөх, уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээний тухай" | Энэ ажлын хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөөг боловсруулан ГЕГ-ын даргаар 2023.06.02-ны өдөр батлуулсан. 2023 оны 8, 11, 12, 2024 оны 04, 07, 10 дугаар саруудад 6 удаа биелэлтийг гаргаж, ЭЗХЯ-ны ТХБД-д албан бичгийн хавсралтаар хүргүүлсэн. 2024 оны 3 дугаар улирлын | 2024.01.01<br>2024.11.30 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | монгол улсын засгийн газрын 178 дугаар тогтоолын хүрээнд хийх ажлын төлөвлөгөө боловсруулж ажиллах | байдлаар 84.6 хувийн гүйцэтгэлтэй. 2024 оны жилийн эцсийн биелэлтийг 2025.01.06-ны өдрийн дотор ЭЗХЯ-д хүргүүлнэ. Хэрэгжилт: ЭЗХЯ-ны ТНБД-ын 2023.08.10-ны өдрийн А/138 дугаартай тушаалаар байгуулагдсан Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 178 дугаар тогтоолын 1 дэх хэсэгт заасан Гадаад худалдааны цахим нэг цонх" мэдээллийн системийг бий болгох, гадаад худалдаатай холбоотой төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх үйл ажиллагааг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан эхлүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсэгт гаалийн байгууллагын төлөөлөл ажиллаж байна. Монгол улсад гадаад худалдааны харилцааг зохицуулах тарифын бус хязгаарлалтын аргаас бүртгэлийн хэлбэрийг хамгийн өргөн хэрэглэдэг бөгөөд улсын хилээр нэвтрүүлэх тодорхой нэрийн бараанд тусгай зөвшөөрөл болон бүртгэл олгох замаар төрөөс хяналт тавьж байна. Иймд гадаад худалдаатай холбоотой дээрх зөвшөөрлийг олгодог байгууллагууд цахим нэг цонх мэдээллийн системийг ашиглаж, олон төрлийн үйлчилгээ, мэдээллийг нэг дор төвлөрүүлсэнээр гаалийн байгууллагын үйл ажиллагааг хялбарчилж, гадаад худалдаанд оролцогч нарт чирэгдэлгүй орчин бүрдүүлэхийг зорьж ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд:<br><br>1.Гаалийн бүрдүүлэлтийн автоматжуулсан CEPS, CAIS системд нэмэлт хөгжүүлэлт хийж, эм, эмнэлгийн хэрэгслийн импортын мэдүүлгийг E-mongolia болон эмийн бүртгэл, мэдээллийн Licemed системээс цахимаар татаж, гаалийн бүрдүүлэлт хийдэг болгосон.<br><br>2.Онцгой албан татвартай барааны хяналтыг сайжруулах зорилгоор тусгай зөвшөөрөл, онцгой албан татварын тэмдэгтэй холбоотой мэдээллийг ХХААХҮЯ, Татварын Ерөнхий газартай солилцох системыг хийлгэсэн.<br><br>3.Озон задалдаг, дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар өндөртэй бодис болон бусад орлуулах бодис, тэдгээрийг агуулсан, ашигласан тоног төхөөрөмжийг импортлох, худалдах, ашиглах зөвшөөрлийг цахимжуулан, CAIS-т | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | холбож, мэдээлэл солилцох системийг 2024.12.16-ны өдрөөс туршиж, нэвтрүүлсэн.<br><br>Гаалийн байгууллагын төлөөлөл тус ажлын хэсгийн 2024 оны 3, 6 дугаар сард зохион байгуулагдсан хурлуудад оролцсон. Харин "Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл"-ийг хэрэгжүүлэгч байгууллага өөрчлөгдөж, ажлын хэсгийн төлөвлөгөөнд тусгасан хугацаа шинэчилэгдсэнтэй холбоотойгоор 2024 оны 3, 4 дүгээр улиралд хурал зохион байгуулагдаагүй болно. | | |
| 2 | Биелэлтэд хяналт тавьж ажиллах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Гаалийн байгууллагын цахим шилжилтийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө | Гаалийн цахим үйлчилгээний систем https://gaali.mn/ -ээс "Барааны экспорт, импортын статистикийн мэдээлэл"-ийг 2023 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар 481 аж ахуй нэгж, иргэн авсан хандалт хийсэн бол 2024 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар 1867 аж ахуй нэгж, иргэн авсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1386 хэрэглэгчээр буюу 4 дахин өссөн үзүүлэлттэй байна. /Эх сурвалж: Gaali.mn Статистик цонхон дахь хандалтын тоогоор/ Мөн Гаалийн цахим үйлчилгээний систем https://gaali.mn/-ээс "Гаалийн мэдүүлгээр бүрдүүлэлт хийсэн барааны лавлагаа" авахаар 2023 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар 19934 аж ахуй нэгж, иргэн хандсан бол 2024 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар 39754 аж ахуй нэгж, иргэн авсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 99%-аар өссөн үзүүлэлттэй байна. /Эх сурвалж: И-Монголиа академи / | 2024.01.01<br>2024.11.30 | 100 |
| 3 | Биелэлтэд хяналт тавьж ажиллах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Монгол улс, БНХАУ-ын гаалийн байгууллагын хилийн хамтарсан шалгалтын ажлын хэсгийн 10 дугаар хуралдааны протоколыг хэрэгжүүлэх ажлын | Хийгдэх ажлын төлөвлөгөөг 2023.10.13-ны өдөр баталсан. Төлөвлөгөөний биелэлтийг гаргаж, хяналт шинжилгээ, үнэлгээ хийлгэхээр 2024.12.24-ний өдөр ХШҮДАГ-т хүргүүлсэн болно. | 2024.01.01<br>2024.11.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | төлөвлөгөө боловсруулж ажиллах | | | |
| 4 | Биелэлтэд хяналт тавьж ажиллах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Монгол улс, БНХАУ-ын хилийн гаалийн байгууллагын холбоо баригч дарга нарын 2023 оны уулзалтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулж ажиллах | Хийгдэх ажлын төлөвлөгөөг 2023.11.02-ны өдөр баталсан. Төлөвлөгөөний биелэлтийг гаргаж, хяналт шинжилгээ, үнэлгээ хийлгэхээр 2024.12.24-ний өдөр ХШҮДАГ-т хүргүүлсэн болно. | 2024.01.01 2024.11.30 | 100 |
| 5 | Биелэлтэд хяналт тавьж ажиллах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | “Бүрдүүлэлтийн цаг хугацааны судалгааны тайлан-2023”-ын зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө | Хийгдэх ажлын төлөвлөгөөг 2024.07.08-ны өдөр баталсан. Төлөвлөгөөний биелэлтийг гаргаж, хяналт шинжилгээ, үнэлгээ хийлгэхээр 2024.12.24-ний өдөр ХШҮДАГ-т хүргүүлсэн болно. | 2024.01.01 2024.11.30 | 100 |
| 6 | Биелэлтэд хяналт тавьж ажиллах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Монгол Улсын ГЕГ-ын ХБГ болон ОХУ-ын ХГА-ны Сибирийн гаалийн газар, Алс дорнодын гаалийн газар хоорондын хилийн холбоо баригч дарга нарын 2023 оны уулзалтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулж ажиллах | Хийгдэх ажлын төлөвлөгөөг 2024.07.28-ны өдөр баталсан. Төлөвлөгөөний биелэлтийг гаргаж, хяналт шинжилгээ, үнэлгээ хийлгэхээр 2024.12.24-ний өдөр ХШҮДАГ-т хүргүүлсэн болно. | 2024.01.01 2024.11.30 | 100 |
| 7 | Биелэлтэд хяналт тавьж ажиллах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | TIR-EPD-г Монгол улсын гаалийн байгууллагын CAIS системтэй | Гаалийн байгууллагын CAIS системд ТИР -ын гаалийн урьдчилсан цахим мэдүүлгийн систем /TIR-EPD/- ийг холбож, 2024.11.24-ний өдрөөс нэвтрүүлж эхэлсэн. Үүний үр дүнд ТИР карнейн хяналтыг сайжруулж, IRU-ын TIR-EPD-г нэвтрүүлсэн | 2024.01.01 2024.11.30 | 100 |

<table>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td>уялдуулж, холбох ажлын төлөвлөгөө боловсруулж ажиллах</td><td>45 улс хооронд солилцох мэдээллийг цахимаар хүлээн авч илгээж байна.</td><td></td><td></td></tr>
<tr><td>8</td><td>Биелэлтэд хяналт тавьж ажиллах</td><td>Хэрэгжилт, гүйцэтгэлээр</td><td>-</td><td>АТГ-ын Мөрдөн шалгах хэлтсээс ирүүлсэн мөрдөгчийн мэдэгдлийн хүрээнд гаалийн хяналт, шалгалтын үр дүнг нэмэгдүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулж ажиллах</td><td>АТГ-ын Мөрдөн шалгах хэлтсээс 2024 онд ирүүлсэн “Гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг арилгуулах тухай” мөрдөгчийн мэдэгдлүүдийг үндэслэн цаашид дээрх мөрдөгчийн мэдэгдлүүдэд дурдагдсан гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгах зорилгоор ажил сайжруулах 12 арга хэмжээтэй нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2024.09.12-ны өдөр батлуулан хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна. Дээрх төлөвлөгөөний хүрээнд ГЕГ-ын холбогдох бүтцийн нэгж, гаалийн газар, хорооны дарга нараас хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар авч, гарсан үр дүнг нэгтгэж, ХШҮДАГ-т хүргүүлэн хяналт, шинжилгээ хийлгэж, гүйцэтгэл 87 хувиар үнэлэгдсэн.<br><br>Дараагийн биелэлтийг 2025.01.10-ны өдрийн байдлаар дахин нэгтгэж, танилцуулна. Тус төлөвлөгөөний биелэлтийг 2024.11.08-ны өдөр АТГ-т хүргүүлсэн.</td><td>2024.01.01<br>2024.11.30</td><td>100</td></tr>
<tr><td>9</td><td>Биелэлтэд хяналт тавьж ажиллах</td><td>Хэрэгжилт, гүйцэтгэлээр</td><td>-</td><td>Замын-Үүд боомтын ачааллыг бууруулах, гаалийн хяналт шалгалтыг сайжруулах чиглэлээр гаалийн байгууллагаас авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж ажиллах</td><td>Хийгдэх ажлын төлөвлөгөөг 2024.10.10-ны өдөр баталсан. Тухайн төлөвлөгөөнд нийт 4 хэсэгт хамаарах 12 ажил тусгагдсан.<br><table>
<tr><td>Биелэлт хангагдсан</td><td>Биелэлт хангагдаагүй</td></tr>
<tr><td colspan="2">НЭГ. Хилийн гаалиас гүний гаалийн хяналтад барааг илгээх үеийн гаалийн хяналтын тогтолцоог боловсронгуй болгох:</td></tr>
<tr><td>1.1, 1.2, 1.4</td><td>1.3, 1.5</td></tr>
<tr><td colspan="2">ХОЁР. Гаалийн газар хорооны бүрдүүлэлтийг зарим бараагаар хязгаарлалт тогтоох боломжийг судлах:</td></tr>
</table></td><td>2024.01.01<br>2024.11.30</td><td>100</td></tr>
</table>

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2.1 | | |
| | | | | | ГУРАВ. Ачаа тээвэрлэлт: | | |
| | | | | | 3.4 — 3.1, 3.2, | | |
| | | | | | ДӨРӨВ. Бусад: | | |
| | | | | | 4.1 — 4.2, 4.3 | | |
| ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛААР БАЙГУУЛАГДСАН АЖЛЫН ХЭСЭГ | | | | | | | |
| 1 | Ажлын хэсгийн даргаар ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | ГЕГ-ын даргын 2024.02.27-ны өдрийн А/124-р тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажилласан байна. | Дэлхийн худалдааны байгууллагын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах худалдааг хөнгөвчлөх үндэсний хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийн даргаар ажиллаж байна. Гадаад худалдаатай холбоотой төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх ажлын явцын биелэлтийг улирал бүр дүгнэж, 3-р улирлын байдлаар 84,6 хувийн гүйцэтгэлтэй бөгөөд жилийн эцсийн биелэлт 2025 оны 1-р сарын 10-ны өдрийн дотор гаргана. | 2024.01.01<br>2024.11.30 | 100 |
| 2 | Үнэлгээний хорооны даргаар ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | ГЕГ-ын даргын 2024.03.06-ны өдрийн А/130-р тушаалаар байгуулагдсан үнэлгээний хороонд ажилласан байна. | Зарим хилийн боомтуудад хүний биеийн халуун хэмжигч, металл мэдрэх, зориулалттай гаалийн хяналт шалгалтын тоног төхөөрөмжийг нийлүүлэх тендерийн үнэлгээний хорооны даргаар ажилласан. | 2024.01.01<br>2024.11.30 | 100 |
| 3 | Үнэлгээний хорооны даргаар ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | ГЕГ-ын даргын 2024.03.06-ны өдрийн А/132-р тушаалаар байгуулагдсан үнэлгээнй хорооны даргаар ажилласан байна. | Зарим хилийн боомтуудад ариутгалын байгууламж, тоног төхөөрөмж нийлүүлэх тендерийн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны даргаар ажилласан. 7-р сарын 3-ны өдөр ариутгалын тоног төхөөрөмжийн үнэлгээний хорооны уулзалтад оролцож байр сууриа илэрхийлсэн. | 2024.01.01<br>2024.11.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | Үнэлгээний хорооны даргаар ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | ГЕГ-ын даргын 2024.05.28-ны өдрийн А/318-р тушаалаар үнэлгээний хороонд ажилласан байна. | Хилийн боомтуудад ариутгалын байгууламж, тоног төхөөрөмж /Алтанбулаг, Боршоо/ нийлүүлэх тендерийн үнэлгээний хорооны даргаар ажилласан. | 2024.01.01 2024.11.30 | 100 |
| 5 | Ажлын хэсгийн ахлагчаар ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | ГЕГ-ын даргын 2024.06.06-ны өдрийн А/339-р тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажилласан байна. | Төсвийн орлогыг биелүүлэхтэй холбоотой гаалийн хяналт, бүрдүүлэлтийн үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийн ахлагчаар ажилласан. | 2024.01.01 2024.11.30 | 100 |
| 6 | Ажлын хэсгийн ахлагчаар ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | ГЕГ-ын даргын 2023.01.03-ны өдрийн А/01-р тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг, ГЕГ-ын даргын 2024.10.09-ны өдрийн А/548-р тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт тус тус ажилласан байна. | ГЕГ-ын үйл ажиллагааны стратеги,зохион байгуулалтын өөрчлөлтийн хөтөлбөрийн төсөл боловсруулах ажлын хэсгийн даргаар ажилласан. Гаалийн байгууллагын 2025-2028 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөний төслийг боловсруулах ажлын хэсгийг 6 удаа хуралдуулж, ажлын хэсэгт Удирдлагын академийн багш Болдыг зөвлөхөөр оролцуулсан. Стратеги төлөвлөгөөний төсөлд зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдээс санал авч нэгтгэн төслийг эцсийн байдлаар бэлэн болгосон. | 2024.01.01 2024.11.30 | 100 |
| 7 | Үнэлгээний багийн ахлагчаар ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | ГЕГ-ын даргын 2024.12.05-ны өдрийн А/628-р тушаалаар байгуулагдсан үнэлгээний багийн ахлагчаар ажилласан байна. | Албан хаагчдийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлэх, хянаж баталгаажуулах мэдээлэх үүрэг бүхий үнэлгээний багийн гишүүдийг 3 удаа хуралдуулж, хүн нэг бүрээр хэлэлцэн үнэлгээг нэгтгэж, Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэсэн болно. | 2024.01.01 2024.11.30 | 100 |
| 8 | Ажлын хэсгийн үйл ажиллагаанд | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн хэрэгжилтийг сайжруулж, улсын орлогын төлөвлөгөөг биелүүлэх | Гаалийн байгууллагын улсын төсвийн орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлэхэд анхаарах, харьяа гаалийн газар, хороодын гаалийн хяналт, бүрдүүлэлтийн үйл ажиллагаа | 2024.01.01 2024.11.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хяналт тавьж ажиллах | | | арга хэмжээний удирдамж баталж, ажлын хэсгийн гишүүдэд хяналт тавьж ажилласан байна. | холбогдох хууль, журмын дагуу хийгдэж буй хяналт тавих зорилготой ажлын хэсэгт ажилласан. | | |
| 9 | Батлагдсан удирдамжийн дагуу газар хороодод ажиллах. | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | ГЕГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу харъяа гаалийн газар хороодод ажилласан байна. | зарим гаалийн газар, хороодын үйл ажиллагаатай танилцаж, цаашид авах арга хэмжээний санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн удирдамжийн дагуу ГСГГ-т 11-р сарын 22-24 өдөр, 9-р сарын 4-7 хооронд СШГГ, ЗҮГГ-т ажилласан ажлын хэсгийн мэдээлэл хийж, цаашид авах арга хэмжээний талаархи чиглэлийг тодорхойлсон. | 2024.01.01<br>2024.11.30 | 100 |

Гурав. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Монгол бичгийн түвшинг сайжруулах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Анхан шатны мэдлэгтэй. | Дүрмээ сайжруулах | Монгол бичгийн дүрэм ярианы сургалтыг бие даан эзэмшиж анхан шатны мэдлэгээ ахиулсан болно. Өдөрт 30 мин -ийг зарцуулж нийт 20 хүн өдөр зарцуулсан | 2024.01.01<br>2024.11.30 | 100 |
| 2. | Гаалийн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр сургалт, семинарт оролцох | Хэрэгжилт, гүйцэтгэлээр<br>Сургалтын тоогоор | Сургалт, семнарит оролцсон. | Бодлого хэрэгжүүлэх чиглэлээр оролцсон байна | Нийт 110 арга хэмжээнд оролцож гаалийн байгууллагын үйл ажиллагааг сурталчлан таниулсан байна. Үүнд: УИХ, ЗГ, УОК, ОУБ-ын хурал хэлэлцүүлэг-19, гаалийн байгууллагын дотоод хурал 18, ажлын хэсгийн хурал 16, хяналт шалгалттай холбоотой семинар, уулзалтад 29, гадаад хамтын ажиллагааны чиглэлээр 23, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ярилцлага 5 удаа, 669 албан бичигт албан тоотоор хариу өгч ажилласан байна. | 2024.01.01<br>2024.11.30 | 100 |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭД ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ ................................ /Г.ЭНХТАЙВАН / ......... ......... .........

*( Албан тушаал )* *( Нэр, гарын үсэг )* *( Огноо )*

ДЭД ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Г.ЭНХТАЙВАНЫ 2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар
Нэгжийн нэр: Дэд дарга

**1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ | Гүйцэтгэлийн түвшин | Нийт оноо (70 оноо) |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт | | 63,04 |

**2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|---|
| 1 | Монгол бичгийн түвшинг сайжруулах | | 15 |
| 2 | Гаалийн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр сургалт, семинарт оролцох | | 15 |
| **Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо** | | | 15 |

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ**

| Д/д | Үзүүлэлт | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|
| 1 | Хандлага, ёс зүй | 15 |
| 2 | Удирдан зохион байгуулах | 10 |
| 3 | Асуудал шийдвэрлэх | 10 |
| 4 | Манлайлах | 10 |
| 5 | Багаар ажиллах | 10 |
| 6 | Харилцаа | 15 |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | |
| 7 | Мэргэжлийн ур чадвар | – |
| **Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо** | | 11,67 |

**4. Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1 | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт | 63,04 |
| 2 | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | 15 |
| 3 | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ | 11,67 |

| | |
|---|---|
| **Нийт оноо=**<br>(Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо+Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо+Хандлага, ёс зүй, ур чадварын оноо) – Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо | 89,7 |

**Үнэлгээ өгсөн:** **Төсвийн шууд захирагч**

Гаалийн ерөнхий газрын дарга ........................ (Р.Отгонжаргал)

2024.12.19 (огноо)

**Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:** **Нэгжийн дарга:**

Дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ........................ (Г.Энхтайван)

2024.12.20 (огноо)